



**УУЛ УУРХАЙН
САЛБАР ДАХЬ
ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН
ТОГТОЛЦОО,
ҮР НӨЛӨӨ**

**СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**



УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн ахлагч:

Б.Солонго, хуульч, өмгөөлөгч, судлаач

Судлаачид:

Т.Замбага, хуульч, өмгөөлөгч, судлаач

М.Гэрэлмаа, хуульч, судлаач

Улаанбаатар хот
2022 он

ННА 33
ДАА 622
З-251



УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО, ҮР НӨЛӨӨ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны багийн ахлагч: Б.Солонго, хуульч, өмгөөлөгч, судлаач
Судлаачид: Т.Замбага, хуульч, өмгөөлөгч, судлаач
М.Гэрэлмаа, хуульч, судлаач

Хавтсанд “Хил хязгааргүй алхам” ТББ-ын үйл ажиллагааны зургуудаас оруулав.

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-8-0

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Манай улсын хувьд тогтвортой хөгжлийг дэмжихүйц хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын нэг нь хууль тогтоомжийн хэрэгжилт болоод байна. Уул уурхайн салбарт хяналтын чиг үүрэг хэрэгжүүлдэг олон байгууллага бий. Тухайлбал, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, түүний орон нутаг дахь харьяа агентлагууд, орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, экологийн цагдаагийн газар өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьдаг. Эдгээр байгууллагын хяналтын чиг үүргийн ялгаа зааг тодорхойгүй, зарим талаар давхардсан, мэргэжлийн хяналтаас бусад байгууллагын хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх үйл явц хуульчлагдаагүйн улмаас хуулийн хэрэгжилтийг сайжруулах, нийтийн эрх ашиг, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд хяналт шалгалтын үзүүлэх үр нөлөө хангалтгүй хэвээр байна. Мөн аж ахуйн нэгжүүдэд багагүй ачаалал дарамт үүсгэдэг ажээ.

Төрийн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэхэд мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоог илүү оновчтой болгох, хүний нөөц, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах явдал чухал гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Иймд хяналт шалгалтын тогтолцоо, түүний үр нөлөөтэй байдлыг эргэн харж бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийг 2003 онд шинэчлэн баталснаас хойш 2006, 2010, 2011, 2015, 2017 онд тус тус, нийт зургаан удаа нэмэлт өөрчлөлт оруулжээ. Гэхдээ эдгээр нэмэлт, өөрчлөлт нь төрийн хяналт шалгалтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг шийдвэрлэхээс илүүтэй бусад салбарын хуулиудад орсон өөрчлөлтийг дагаж хийгджээ. Түүнчлэн 2014 онд Хяналтын тухай хуулийн төсөл боловсруулагдсан ч УИХ-д өргөн баригдаагүй байна.

Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэлэлцүүлэгт энэхүү судалгаа тодорхой хувь нэмэр оруулна гэдэгт бид итгэж байна. Судалгааг хийж гүйцэтгэсэн судлаач Б.Солонго, Т.Замбага, М.Гэрэлмаа болон судалгааны тайланг бэлтгэхэд үнэтэй санал зөвлөгөө өгч ажилласан ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер Д.Эрдэнэчимэгт талархал илэрхийлье.

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

ТОВЧЛОЛ	7
УДИРТГАЛ	8
Судалгааны зорилго	8
Сэдвийн судлагдсан байдал	10
Судалгааны арга зүй	11
Судалгааны тайлангийн бүтэц	12
НЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ	
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО	14
1.1. Уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын тогтолцоо	14
1.1.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо	16
1.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо	20
1.1.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоо	23
1.1.4. Бичил уурхайн хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоо	23
1.1.5. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо	25
1.1.6. Уул уурхайн салбарт байгаль орчны хяналт хэрэгжүүлэх субъект	27
1.1.7. Хяналт хэрэгжүүлэгч субъектийг тодорхойлохтой холбоотой практикийн зарим асуудал	29

1.2. Уул уурхайн салбар дахь	
мэргэжлийн хяналтын тогтолцоо	33
1.2.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар	
тогтоосон мэргэжлийн хяналтын байгууллагын	
тогтолцоо	33
1.2.2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар	
тогтоосон мэргэжлийн хяналтын байгууллагын	
тогтолцоо	35

ХОЁР. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ

41

2.1. Хяналт шалгалтын үр нөлөөтэй байдлын	
шалгуур үзүүлэлт	41
2.2. Уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын үр нөлөө	42
2.3. Уул уурхайн салбарт мэргэжлийн хяналтыг	
хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудлууд	44
2.3.1. Хяналт шалгалтын тогтолцоо нь хяналт шалгалтын	
үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь	44
2.3.2. Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил хяналт шалгалтын	
үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь	49
2.3.3. Хяналт шалгалтыг объектын эрсдэлийн ангилалд	
үндэслэн явуулах нь үр нөлөөтэй байдалд	
нөлөөлөх эсэх	54
2.3.4. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон	
гүйцэтгэлийн хяналт шалгалтын	
үр нөлөөтэй байдал	57
2.3.5. Хяналтын хуудас нь хяналт шалгалтын	
үр нөлөөтэй байдалд нөлөөлөх эсэх	60
2.3.6. Мэргэжлийн хяналтын байгууллагын	
үйл ажиллагаатай холбогдон үүсэж буй	
хүндрэлтэй асуудал хяналт шалгалтын	
үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь	71

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА	75
3.1. Австрали Улсын уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын тогтолцоо	75
3.2. Канад Улсын уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын тогтолцоо	77
СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ	81
СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ	86
Ашигласан эх сурвалж	89
Хавсралт	91

ТОВЧЛОЛ

АМтХ	Ашигт малтмалын тухай хууль
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУтХ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
БОХтХ	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
ЗШШтХ	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТХШтХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
ТТАМтХ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Шинэ тулгар Ардын засгаас 1922 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Налайхын нүүрсний уурхайг улсын болгох шийдвэр гаргаснаар Монгол Улсад уул уурхайн салбар үүсэж хөгжих үндэс суурь тавигджээ. Хэдийгээр он тооллын хувьд уул уурхайн салбар Монгол Улсад үүсэж хөгжөөд нэгэн зууны босго давах гэж буй боловч эдийн засаг, аюулгүй байдал, хүний эрх, хүрээлэн буй орчны тэнцвэртэй байдлыг хангах оновчтой, цогц эрх зүйн зохицуулалт бий болж чадаагүй хэвээр байна. Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш 1994 ба 1997 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хууль (АМТХ) нь зохицуулалтын хувьд ашигт малтмал хайх, олборлох болон ашиглахтай холбоотой үүсдэг бүх харилцааг бүрэн хамарч, орчин үеийн уул уурхайн хуулийн шинжийг бүрэн хангаж чадаагүй юм. Харин 2006 онд Ашигт малтмалын тухай хуулийг шинэчлэн баталсан нь ашигт малтмалын эрэл, хайгуул, ашиглалтын эрх зүйн орчныг олон улсын сайн практикт тулгуурлан бүрдүүлэх, экспортын чиг хандлагатай уул уурхайн үйлдвэрлэлийг дэмжих, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх суурь нөхцөлүүд бүрдүүлсэн чухал алхам болжээ.

Үе үеийн Засгийн газраас уул уурхайн салбарыг эдийн засгийн тэргүүлэх салбараар тодорхойлон, түүний эдийн засагт үзүүлэх хувь нэмрийг нэмэгдүүлэх, томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулж, хөрөнгө оруулалт татахад чиглэсэн үе шаттай тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсээр иржээ. Гэсэн хэдий ч уул уурхайн компаниуд, бичил уурхай эрхлэгчид хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх, иргэдийн зүгээс ч хууль тогтоомжийн хийдэл, зөрчлийг ашиглан хууль бусаар ашигт малтмал олборлож, хүрээлэн буй орчинд хохирол учруулах явдал гарсаар байна. Энэ нь олон нийтийн зүгээс, ялангуяа олборлолт эрчимтэй явагдаж буй

орон нутагт амьдарч буй иргэдийн зүгээс уул уурхайн үйл ажиллагааг сэргөөр хүлээн авах гол шалтгаануудын нэг болж байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх¹-ийг хангаж, ирээдүй хойч үеийн эрх, ашиг сонирхол, эрэлт хэрэгцээг хөндөхгүйгээр нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгаа зөв, оновчтой ашиглах нөхцөл бүрдүүлэх нь чухал юм. Ингэх аваас Монгол Улсад олон улсын жишигт нийцэх хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлж,² түүгээр дамжуулан эдийн засгийн бусад салбараа өргөжүүлэн, хүртээмжтэй, тогтвортой өсөлт хөгжлийг хангах юм.

Дэлхийн хамтын нийгэмлэгийн байгууллагуудаас сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжлийг хангахад ихээхэн анхаарал хандуулж, хүрээлэн буй орчныг хамгаалах замаар тогтвортойгоор хөгжих арга зам нэвтрүүлэхийг уриалж байна. Монгол Улс XXI зууны хөгжлийн хөтөлбөр болон Алсын хараа-2050 бодлогын баримт бичгүүддээ эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш байдал, тогтвортой хөгжил ба байгалийн баялгийн зөв зохистой ашиглалт гурвыг эн тэнцүү авч үзсэн хөгжлийн нэгдмэл стратегийг тодорхойлсон байдаг. Эндээс хүрээлэн буй орчныг хамгаалах замаар уул уурхайн салбарыг хөгжүүлэх шаардлага урган гарч байгаа юм.³

Монгол Улсад хариуцлагатай уул уурхай хөгжүүлэх хамгийн гол нөхцөл болох хяналт шалгалтын зөв, оновчтой тогтолцоо бүрдсэн эсэх, цаашлаад хяналт шалгалт үр нөлөөтэй байх урьдчилсан нөхцөл, механизмууд бүрдсэн эсэх нь судлаачид, уул уурхайн компаниуд, энэ салбарт холбогдох төрийн байгууллагуудын анхаарлыг татсаар байна.

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт.

² Азийн Сангаас 2006 онд олон талт сонирхлын бүлгүүдийн төлөөллийн саналыг харгалзан томъёолсон “Хариуцлагатай уул уурхай”-н тодорхойлолт. <https://asiafoundation.org/resources/pdfs/MGMultistakeholderIV.pdf>

³ Э.Байгал, Д.Баяр болон бусад, “Гадаадын хөрөнгө оруулалт: Эрх зүйн асуудал” гарын авлага, УБ., 2010.

Иймд уул уурхайн салбар дахь хяналт шалгалт, түүний үр нөлөөг судлан шинжилж, хяналт шалгалтын тогтолцоог оновчтой болгох, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад энэхүү судалгааны ажлын үндсэн зорилго оршиж байгаа юм.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

Ё.Баттогтохын 2005 онд хэвлүүлсэн “Төрийн хяналт шалгалт” ном нь төрийн хяналт шалгалтын чиглэлээр тусгайлан хэвлэгдсэн цөөн бүтээлийн нэг юм. Гэвч уг номд Төрийн хяналт шалгалтын тухай хууль (ТХШТХ) 2003 онд батлагдсантай холбоотойгоор хуульд тусгагдсан шинэ зохицуулалтуудыг тайлбарласан хэдий ч төрийн хяналт шалгалтыг тогтолцоо талаас нь цогц байдлаар авч үзээгүй, уг асуудлаар дүгнэлт гаргаагүй юм.

Харин 2020 онд Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын санаачлан боловсруулсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбоотойгоор “Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан”-г боловсруулж, төрийн холбогдох байгууллагуудаас санал авсан боловч тайланг олон нийтэд танилцуулаагүй байна. Уг тайланд төрийн хяналт шалгалтын тогтолцооны талаар тусгайлан хэсэг оруулсан байх боловч хуулиар тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналтын байгууллагаас бусад төрийн захиргааны байгууллагад хамаарах нийтлэг хэм хэмжээг тусгаагүйг онцлон тэмдэглэсэн байдаг.

Захиргааны хэргийн шүүхээр 2016 оноос 2020 оны наймдугаар сар хүртэлх хугацаанд шийдвэрлэсэн байгаль орчны хяналт шалгалттай холбоотой хэрэг, маргааны тоог тодорхойлох зорилгоор шүүхийн шийдвэрийн нэгдсэн системд шүүлт хийхэд анхан шатны шүүхээр 165, давж заалдах шатны шүүхээр 44, харин Улсын Дээд шүүхээр 24 хэрэг маргаан шийдвэрлэгдсэн байна. Гэхдээ энэхүү судалгааны судлагдахууны чиглэлээр шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн бүтээл байхгүй байна.

Дээрх нөхцөлийг харгалзан уул уурхайн салбар дахь төрийн хяналт шалгалтын тогтолцооны үр нөлөөг үнэлэх ажлыг Нээлттэй Нийгэм

Форумын дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэлээ. Уг судалгаанд Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг удирдлага болгож ажиллалаа.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Уул уурхайн салбарын хувьд эрэл, хайгуул, ашиглалт болон олборлолтын явцад хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, аюулгүй байдлыг хангах, уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсийг хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор олон чиглэлээр хяналт шалгалт хийх шаардлагатай байдаг. Тиймээс энэхүү судалгаанд зөвхөн уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналт шалгалтын тогтолцоо, үр нөлөөг авч үзсэн болно. Учир нь уул уурхайн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад зөвхөн төрийн байгууллага төдийгүй төрөөс хэрэгжүүлэх хяналтын үр нөлөөг сайжруулахын тулд хөрөнгө оруулагч, уул уурхайн компаниуд ч анхаарах ёстой. Учир иймд энэхүү судалгаа болон судалгааны дараах цуврал хэлэлцүүлгээр дамжуулан дээрх асуудалд холбогдох талуудын анхаарлыг хандуулан, тэдний хамтын ажиллагааг сайжруулахыг зорьсон болно.

Судалгааны үндсэн зорилгын хүрээнд уул уурхайн салбарын болон төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлох гол хууль тогтоомжуудад дүн шинжилгээ хийсэн болно. Түүнчлэн уг асуудлаар өмнө нь хийгдсэн судалгаа, тайлангуудыг шинжлэн үзлээ.

Баримт бичгийн шинжилгээний хүрээнд (i) холбогдох хууль тогтоомжид; (ii) уул уурхайн салбар дахь хяналт шалгалт, тэр дундаа мэргэжлийн хяналттай холбоотой эрдэм шинжилгээ, судалгааны зарим бүтээл, нийтлэл, тайланд дүн шинжилгээ хийж; (iii) холбогдох бусад улсын хууль тогтоомж, тэдгээрийг хэрэглэж байгаа практикийг судаллаа.

Судалгааны хүрээнд уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын эрх зүйн тогтолцоонд дүн шинжилгээ хийх зорилгоор хяналт шалгалттай холбоотой харилцааг зохицуулж буй гол хууль болох ТХШтХ, цаашлаад уул уурхайн салбарын харилцааг зохицуулж буй Ашигт малтмалын тухай хууль (АМтХ), байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах талаар аж ахуйн нэгжүүдийн хүлээх үүргийг тодорхойлсон Байгаль орчныг хамгаалах тухай хууль (БОХтХ), Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБҮтХ) зэрэгт хийдэл, давхардал, зөрчлийн дүн шинжилгээ хийсэн болно.

Мөн уул уурхайн салбарт төрийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй хяналт шалгалтын үр нөлөө, хяналтын байгууллага, албан тушаалтны шийдвэр, заавар зөвлөмжийг аж ахуйн нэгжүүд хэрхэн биелүүлж байгаад дүн шинжилгээ хийв. Энэ хүрээнд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлж буй байгууллага, албан тушаалтны шийдвэр нь холбогдох хууль тогтоомжоор тавьсан зорилгыг хэрэгжүүлж чадаж байгаа эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаад дүн шинжилгээ хийж, тулгамдсан асуудлыг тодорхойлон дүгнэлт, санал боловсрууллаа.

Цаашлаад хяналт шалгалтын тогтолцооны оновчтой, үр нөлөөтэй байдлыг үнэлэхэд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын төлөөлөл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ), Байгаль орчин, аялал жуулчлалын яам (БОАЖЯ), Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) болон мэргэжлийн хяналтын байгууллага, улсын болон сумын байцаагч, байгаль хамгаалагч, аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн төлөөллөөс ярилцлагын болон анкетын судалгаа авч, хяналт шалгалттай холбоотой практикт тулгардаг асуудлууд, тэдгээрийн шийдлийг тодорхойлоход харгалзан үзсэн болно.

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ

Судалгааны тайлан нь удиртгал болон гурван бүлгээс бүрдэнэ. Бүтцийг тодорхойлохдоо төрийн хяналт шалгалтын тогтолцооны ойлголт, холбогдох харилцааг зохицуулсан гол хууль тогтоомжийн дүн шинжилгээ, оролцогч субъектүүдийн бүрэн эрхийн хэрэгжилт, уялдаа

холбоо гэсэн дарааллаар авч үзэн, уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналтын тогтолцооны үр нөлөөтэй байдлыг онолын болон практикийн түвшинд авч үзэхийг зорилоо.

Нэгдүгээр бүлгийн хүрээнд үндсэн судлагдахуун болох төрийн хяналт шалгалтын тогтолцоо, тэр дундаа уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналт шалгалтын тогтолцоо, хяналт хэрэгжүүлэгч субъектүүдийн бүрэн эрхийн хүрээ хязгаарыг нарийвчлан судлах зорилгоор салбарын гол хуулиуд болох ТХШТХ, АМтХ, БОХтХ, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (ЗШШТХ)-д дүн шинжилгээ хийв. Үүнд мэргэжлийн хяналтын байгууллагаас уул уурхайн салбарт байгаль орчны хяналт шалгалт хэрэгжүүлэх тогтолцоог онцгойлон авч үзэж, тус байгууллагын үйл ажиллагаа нь хяналт хэрэгжүүлэгч бусад байгууллагын үйл ажиллагаатай хэрхэн уялдаж байгааг тодорхойлон хийдэл, давхардалд дүн шинжилгээ хийлээ.

Хоёрдугаар бүлэгт өмнөх бүлэгт авч үзсэн хууль тогтоомж нь практикт хэр үр нөлөөтэй хэрэгжиж байгаа, холбогдох субъектүүд эрх үүргээ хэрэгжүүлэхэд ямар ямар хүндрэл бэрхшээл тулгарч байгаа, тэдгээр нь хяналт шалгалтын үр нөлөөнд хэрхэн нөлөөлж байгааг бичиг баримтын болон тоон судалгааны аргаар цуглуулсан баримт мэдээлэлд үндэслэн тодорхойлов.

Харин гуравдугаар бүлэгт уул уурхайн салбарт хяналт шалгалт хэрэгжүүлэх бусад улс орны туршлагыг авч үзлээ. Энэ хүрээнд уул уурхайн хөгжлөөрөө тэргүүлэгч Австрали болон Канад улсуудын туршлага, эрх зүйн холбогдох зохицуулалтыг авч үзлээ.

Ийнхүү тайлангийн үндсэн бүтцийн дагуу дээрх гурван бүлгийн хүрээнд хууль тогтоомж болон тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэхтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлон санал, зөвлөмж боловсруулсныг судалгааны төгсгөл хэсэг буюу дөрөвдүгээр бүлэгт танилцуулсан болно.

НЭГ. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

1.1. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасан. Энэхүү заалтын дагуу байгалийн баялгийг ашиглах аливаа бодлого нь иргэн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хөндөхгүй буюу зөрчихгүй байх учиртай бөгөөд цаашлаад Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтаар баталгаажсан “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрх”-ийг хэрэгжүүлэхэд чиглэх учиртай.

Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд Үндсэн хуулийн хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг “Улсын Их Хурал хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар хянан шалгах хороо байгуулах...”, мөн хуулийн гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт “Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, ... нийтлэг чиг үүргийн дагуу Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах үүрэгтэй” шууд хамааралтай. Ийнхүү төрийн хяналт шалгалтын тогтолцооны эрх зүйн нийтлэг үндэслэлийг Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосны дагуу 2003 онд ТХШТХ-ийг батлан гаргажээ.

ТХШтХ батлагдсанаас хойших 17 жилд төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллага болох мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаа бүрэн бэхжиж тогтсон боловч улс орны эдийн засгийн нөхцөл байдал, шинэ тутам хөгжиж буй салбаруудын эрх зүйн зохицуулалтын зөрүүтэй байдлаас үүдэн тодорхой бэрхшээл тулгарсаар байна. Үүний улмаас төрийн хяналт шалгалтыг зарим салбарт нэг мөр, нэгдсэн зохион байгуулалтаар хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгардаг ба тэдгээрийн нэг нь уул уурхайн салбар юм.

Уул уурхайн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хайгуул, олборлолтын явцад болон дараа нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх нь уул уурхайн салбарт төрөөс хэрэгжүүлэх бодлогын хамгийн чухал зорилт юм. Энэхүү зорилтыг биелүүлж, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийг хариуцлагажуулах, ашигт малтмалын хууль бус олборлолтыг таслан зогсоох шаардлагатай байна. Иймээс Монгол Улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд хяналт шалгалтын оновчтой, үр нөлөөтэй тогтолцоо нэн чухал үүрэгтэй юм.

Уул уурхайн салбар дахь хяналт шалгалтыг ТХШтХ-д тодорхойлсон “хяналт шалгалт”⁴ гэх нэр томъёотой уялдуулан тайлбарлавал ердийн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч, бичил уурхай эрхлэгч этгээдийн зүгээс явуулж байгаа үйл ажиллагаа (үйлдэл, эс үйлдэхүй), түүнчлэн үйлдвэрлэж байгаа эсхүл борлуулж буй бараа, бүтээгдэхүүн нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн хяналт шалгалтын цогц арга хэмжээ гэж тодорхойлж болох юм.

Гэвч уул уурхайн салбар дахь хяналт шалгалт, тэдгээрийг хэрэгжүүлэх байгууллагуудын эрх, үүргийг зөвхөн ТХШтХ-иар бус АМтХ, БОХтХ, Зөрчлийн тухай болон ЗШШтХ гэх зэрэг олон хуулиар зэрэг зохицуулдаг. Ийнхүү нэг салбарын асуудлыг хэд хэдэн хууль тогтоомжоор зэрэг зохицуулдаг учраас эдгээр хуулийн хооронд зөрчил, давхардал эсхүл бүр хийдэл үүссэн байхыг үгүйсгэхгүй юм. Гэтэл

⁴ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 3¹.1.1 дэх заалт

эдгээр хууль хоорондоо, тэр дундаа ТХШтХ-тай хэрхэн уялдаж байгааг нарийвчлан судалсан судалгаа, нэг сэдэвт бүтээл одоогоор байхгүй байна.⁵ Энэ нь уул уурхайн салбарт хяналт хэрэгжүүлэгч төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангахад хууль тогтоомжийн зөрчил, давхардлыг нарийвчлан судлах шаардлага байгааг харуулж байна.

1.1.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо

ТХШтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт төрийн хяналт шалгалт нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, төрийн аудитын байгууллага, төрийн захиргааны байгууллага, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалтаас бүрдэхээр зохицуулжээ. Үүнээс Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, төрийн аудитын байгууллага, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэцийн хяналтыг тус тусын хуулиар зохицуулах ба зөвхөн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагын хэрэгжүүлэх хяналт шалгалтад энэ хуулийг дагаж мөрдөхөөр тусгажээ. Өөрөөр хэлбэл, тус хуулийн гуравдугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын хяналт шалгалт, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгогдсон мэргэжлийн хяналт, түүнчлэн нутгийн өөрөө удирдах байгууллагаас энэ хуулийн дагуу хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбогдсон харилцааг тус хуулиар зохицуулна” гэж заажээ.

⁵ Монгол Улсын Засгийн газар болон УУХҮЯ, ХЗДХЯ, БОАЖЯ хамтран Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн дэмжлэгээр байгаль орчин, ашигт малтмалын чиглэлийн хуулиудын хийдэл, зөрчил, давхардлын судалгааг 2017 онд хийжээ. Тус судалгааны хүрээнд Ашигт малтмалын тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих болон Газрын тосны тухай хуулиудад хийдэл, зөрчил, давхардлын дүн шинжилгээ хийсэн байна. Гэхдээ дээрх хуулиуд нь Төрийн хяналт шалгалтын хуультай хэрхэн нийцэж байгааг уг судалгаагаар авч үзээгүй болно.

Цаашлаад ТХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт хяналт шалгалтын байгууллагыг тусгайлан тодорхойлсныг мэргэжлийн хяналтын байгууллага гэж ойлгож болох ба тус хуулийн 5 дугаар зүйлд заасан хяналт шалгалтын нийтлэг үндэслэл, журам нь агуулгын хувьд зөвхөн мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд л хамаарахаар байна. Энэ нь 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан төрийн захиргааны байгууллагуудын хяналт шалгалтад мөрдөх журмыг ойлгомжгүй болгон, практикт хүндрэл учруулж байна.

ТХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасан Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын зүгээс хяналт шалгалттай холбоотой зохицуулалтад дүн шинжилгээ хийж үзвэл ямар байгууллага ямар чиглэлийн хяналтыг ямар журмаар хэрэгжүүлэх талаар ойлгомжтой, цогц зохицуулалт байхгүй байна.

Тухайлбал, тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т зааснаар “Яам, агентлаг болон Засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг ...төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хянан шалгах” эрх, үүрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт явуулах эрх яам, агентлаг болон Засгийн газраас байгуулдаг төрийн захиргааны байгууллагад олгогдсон гэж ойлгож болохоор байна. Гэвч эдгээр байгууллага, албан тушаалтанд ТХШТХ-д заасан улсын байцаагчийн эрх олгогддоггүй тул хийсэн шалгалтынхаа үр дүнг баталгаажуулах, зөрчилд арга хэмжээ авах зэрэг ТХШТХ, Зөрчлийн тухай хууль болон бусад хуульд заасан байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй байна. Жишээ нь, 2018 оны 3 дугаар сарын 23-нд Улсын Их Хурлын даргын захирамжаар “Оюутолгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгаж санал, дүгнэлт гаргах” үүрэг бүхий ажлын хэсэг, 2019 оны 3 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажлыг шалгах ажлын хэсэг тус тус байгуулжээ. Гэхдээ эдгээр нь ТХШТХ-ийн хүрээнд бус Улсын Их Хурлын гишүүд, салбарын яамд, төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг байдлаар байгуулагдаж, илэрсэн зөрчил дутагдлын талаар дүгнэлт гаргах хэмжээнд л ажиллажээ. Тэрчлэн сүүлийн дөрвөн жилд

“Эрдэнэс Монгол” ХХК, “Эрдэнэс Тавантолгой” ХК зэрэг төрийн өмчит компаниудад төрийн захиргааны байгууллагаас ТХШТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтын дагуу хяналт шалгалт хийсэн тохиолдол одоогоор байхгүй байна.

Түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь ТХШТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх хэсэгт заасны дагуу хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын болон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ оршдог нийт байгууллага, аж ахуйн нэгжид тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр хянан шалгах бүрэн эрхтэй. Гэхдээ энэ эрхээ хэрхэн хэрэгжүүлэх асуудлыг тус хуулиар мөн л нарийвчлан зохицуулалгүй үлдээжээ.

Нутгийн өөрөө удирдах байгууллага буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь тус хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцооны нэг бүрдэл хэсэг болохоор байна. ТХШТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дээд шатны болон тухайн хурлын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэрийнхээ холбогдох бүх байгууллага, аж ахуйн нэгжийг харьяалал, өмчийн төрөл, хэлбэр харгалзахгүйгээр хянан шалгах бүрэн эрхтэй. Нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалтыг тус хуулийн гуравдугаар бүлэгт тусгайлан зохицуулсан боловч зөвхөн хяналт шалгалтын чиглэлээр хэрэгжүүлэх бүрэн эрхийг нь л тодорхойлсноос бус, энэхүү эрхээ ямар журмаар хэрэгжүүлэхийг мөн л орхигдуулжээ.

Дээр дурдсан Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага нь хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага гэж тооцогдох боловч хуулийн 5 дугаар зүйлд заасан төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус гүйцэтгэлийн хяналт шалгалтын дийлэнх журам нь эдгээр байгууллагад хамаарахгүй байна. Мэргэжлийн хяналтаас бусад төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хяналтын үйл ажиллагаанд хамаарах ТХШТХ-ийн заалтуудыг Хавсралт 1-ээс үзнэ үү. Тухайлбал, уул уурхайн салбарт АМГТГ, БОАЖЯ зэрэг төрийн захиргааны байгууллага

хяналт шалгалт хийхдээ ТХШтХ-ийн хүрээнд бус, өөр бусад хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд, өөрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтны удирдамжийн дагуу боловсруулсан хяналтын хуудсаараа шалгалт явуулдаг ажээ.

Эндээс үзвэл ТХШтХ-ийн нэг нийтлэг дутагдал, хийдэл нь мэргэжлийн хяналтын байгууллагаас бусад төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны хяналт шалгалт явуулахдаа мөрдөх журам, үйл явцыг зохицуулаагүй үлдээсэн явдал гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл, тэдгээр байгууллага, албан тушаалтан хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт шалгалтыг хэрхэн явуулах, үр дүнг нь хэрхэн баталгаажуулах, зөрчил илрүүлсэн тохиолдолд ямар арга хэмжээ авах, хариуцлага оногдуулах гэх мэт асуудал тодорхойгүй байна. Ингэснээр хяналт шалгалт хийх объектод саадгүй нэвтрэх, зөрчлийг баталгаажуулах, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд шууд ба шууд бусаар хор хохирол учруулж байгаа буюу учруулж болох нь зохих ёсоор нотлогдсон тохиолдолд холбогдох ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн түр болон бүр зогсоох боломжгүй байна. Түүнчлэн шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, тухайн барилга байгууламж, машин, тоног төхөөрөмжийн ашиглалт болон холбогдох бүтээгдэхүүнийг худалдан борлуулахыг хориглох, устгах юм уу өөр зориулалтаар ашиглах шийдвэр гаргах, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг улсын байцаагчийн эдэлдэг олон эрх хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байдаг. Энэ нь эдгээр байгууллагын хяналт шалгалтын үр нөлөөг сааруулж, зөвхөн мэргэжлийн хяналтын байгууллагад зөвлөн туслах байдлаар ажиллахад хүргэж байна.

ТХШтХ-иар бүрэн эрх, үйл ажиллагааны журам нь хамгийн тодорхой зохицуулагдсан хяналт шалгалтын байгууллага бол мэргэжлийн хяналтын байгууллага юм. Мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо, хяналт шалгалтын үйл ажиллагааны зохицуулалтыг энэхүү тайлангийн нэгдүгээр бүлэгт тухайлан авч үзлээ.

*1.1.2. Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд
хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо*

АМтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр заажээ.

Гэвч АМтХ-д “мэргэжлийн хяналтын байгууллага”, “мэргэжлийн хяналтын алба” болон “мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэсэн гурван өөр нэршил хэрэглэсэн нь хэдийгээр зөвхөн нэр томъёоны асуудал мэт харагдавч хууль хэрэглээ талаасаа тодорхой бус байдал үүсгэж байна. Өөрөөр хэлбэл, АМтХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан “мэргэжлийн хяналтын байгууллага”-ыг ТХШтХ-ийн 9 дүгээр зүйлд заасан мэргэжлийн хяналтын байгууллага гэж ойлгож болохоор байгаа бол харин “мэргэжлийн хяналтын алба” гэдэгт яг аль байгууллагыг ойлгохыг АМтХ болон ТХШтХ-ийн аль алинд нь тодорхойлоогүй байна. Мэргэжлийн хяналттай холбоотой АМтХ-ийн зохицуулалтыг судалгааны Хавсралт 2-оос авч үзнэ үү. Хэдийгээр практикт “мэргэжлийн хяналтын алба” гэдгийг “мэргэжлийн хяналтын байгууллага” хэмээн ойлгон хэрэгжүүлж ирсэн боловч Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх хэсэгт заасны дагуу нэр томъёоны нэг нэршил хэрэглэх буюу Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх зарчимд нийцүүлэн өөрчлөх нь зүйтэй.

Цаашилбал АМтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.8-д зааснаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих, 11 дүгээр зүйлийн 11.1.6-д зааснаар хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн энэ хуульд заасан төлөвлөгөө, тайлан, хайгуулын ажлын зардлын доод хэмжээнд хяналт тавих, 11.1.14-т заасны дагуу хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих, харин нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь хэсэгт заасны дагуу байгаль орчныг

хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.

Ийнхүү АМтХ-иар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь тодорхой асуудлаар “хяналт тавих” эрхтэй боловч уг эрхээ ямар журмаар, хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас хяналт шалгалт хийхдээ мөрдөх журмыг ТХШтХ-иар зохицуулаагүй талаар өмнө дурдсан бол тухайн салбарыг тухайлан зохицуулсан хууль тогтоомжид ч энэ асуудал мөн орхигджээ.

Судлаач Ё.Бямбаатогтох “Төрийн хяналт гэдэг нь төрийн байгууллагаас өөрийн эрх хэмжээний хүрээнд төрийн байгууллага болон албан тушаалтны үйл ажиллагаа зохих хууль тогтоомж, журамд хэрхэн нийцэж байгаад тавьж буй ажиглалт гэж тодорхойлсон бол төрийн шалгалт гэдэг нь төрийн хяналт тавигдах явцад аливаа нэг алдаа, зөрчил гарсан байж болзошгүй гэх үндэслэл байгаа тохиолдолд тухайн зөрчлийг илрүүлж, тодорхойлохын тулд явуулж буй аливаа төрлийн (үзлэг, нэгжлэг гэх мэт) ажиллагааг хэлнэ” гэжээ.⁶ Гэхдээ АМтХ болоод холбогдох бусад хуульд “хяналт тавих” гэдэг нэр томъёог тодорхойлоогүй байх тул АМтХ-д заасан хяналт тавих эрхийг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад олгогдсон бүрэн эрх хэмээн үзэж, тусгай зөвшөөрөл эзэмших, бичил уурхай эрхлэгчид хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад “хяналт тавих, үнэлэх, зөвлөн туслах цогц арга хэмжээ” гэж ойлгож болох юм.

Ийнхүү АМтХ болон ТХШтХ-иар төрийн захиргааны байгууллагын хяналтын эрх хэмжээг тусгайлан зохицуулаагүйгээс хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсдэг байна.

⁶ Ё.Бямбаатогтох, Төрийн хяналт, шалгалт, Хоёр дахь хэвлэл, УБ., 2005, 2 дахь тал.

“АМтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.8-д заасан стратегийн ордын үйл ажиллагаанд хяналт тавих геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлэх асуудал эргэлзээтэй байдаг бөгөөд хэрхэн, яаж хяналт тавих, хяналт тавих бүрэн эрхийн хүрээ, хязгаар ямар байх талаар нэгдсэн байр суурь, зохицуулалт байхгүй байна. Энэ талаар тусгайлан журам батлуулахаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлдэг боловч журам батлах эрхийг АМтХ-иар олгоогүй гэх үндэслэлээр буцаагддаг.”

УУХҮЯ-ны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын зүгээс хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих бүрэн эрх нь сонгон шалгаруулалт зарлах, тусгай зөвшөөрөл олгох, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тайлан, төлөвлөгөөг хүлээн авах, батлах, уурхайг ашиглалтад хүлээн авах болон хаах ажлын хэсэгт орж ажиллах, тусгай зөвшөөрлийг цуцлах зэрэг хайгуулын үе шатаас эхлэн уурхайг хаах хүртэлх бүхий л шатанд хэрэгжихээр ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, төрийн захиргааны байгууллагын зүгээс хяналт тавих эрх нь тус хуулиар олгогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх замаар ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаанд хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах тухай асуудал юм.⁷

⁷ 2017 онд хийгдсэн АМтХ-ийн хийдэл, зөрчил, давхардлын судалгаанд “2006 оны АМтХ-ийн байгаль орчны нөлөөллийн үнэлгээний зохицуулалт нь 1998 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (БОНБҮтХ) хүчин төгөлдөр байх үед батлагдсан. БОНБҮтХ батлагдсантай холбогдуулан холбогдох өөрчлөлтийг АМтХ-д дутуу оруулснаас байгаль орчны үнэлгээтэй холбоотой зохицуулалтууд бүхэлдээ ойлгомжгүй болсон байна. Тухайлбал, БОНБҮтХ-иар байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг дөрөв ангилсан. Ашигт малтмал хайх, ашиглах тохиолдолд дээрх дөрвөөс байгаль орчны нөлөөллийн үнэлгээг л хийдэг. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг ерөнхий, нарийвчилсан гэж ангилна. Ерөнхий үнэлгээг хайх, ашиглахад аль алинд нь хийх ба ерөнхий үнэлгээ хийсэн шинжээч шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нарийвчилсан үнэлгээ хийгдэхээр,

Харин АМтХ-иар тодорхойлсон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын хяналт тавих эрх нь зөвхөн тодорхой харилцаа буюу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүн амын эрүүл мэндийг хамгаалах болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаарх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлтэд хяналт тавихаар хязгаарлагдана.

1.1.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоо

2014 онд батлагдсан ТГАМтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ” гэжээ. Мөн тус хуулиар хяналт тавих эрх олгогдсон субъект нь аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал бөгөөд аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3-т зааснаар хүний эрүүл мэнд, байгаль орчин, нөхөн сэргээлт, уурхайн хаалт болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн талаар хүлээсэн үүргээ тусгай зөвшөөрөл эзэмшигч хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих бүрэн эрхтэй байна.

1.1.4. Бичил уурхайн хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоо

АМтХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2-т заасны дагуу бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг журмаар зохицуулах бөгөөд уг журмыг Засгийн газар батална. Энэ бүрэн эрхийнхээ хүрээнд

БОМТ (Байгаль орчны менежментийн төлөвлөгөө)-ний нэг хэсэг нь байгаль хамгаалах төлөвлөгөө байх, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага нь нарийвчилсан үнэлгээг батлахаар байгаа бол АМтХ-д байгууллага нь нарийвчилсан үнэлгээг батлах зэрэг зохицуулалттай. Харин АМтХ-д “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ” гэх ерөнхий нэр томъёо хэрэглэснээс гадна шууд нарийвчилсан үнэлгээний бүрдэл хэсгийг шаардсан, үнэлгээ хийх, хянах, батлах байгууллага нь БОНБҮтХ-д зааснаас өөр байх, зарим эшилсэн заалтын дугаар буруу зэрэг зөрчил байна” гэж дурджээ. Энэ нь байгаль орчны эрх зүйн зохицуулалт болон уул уурхайн салбарын хуулиудын хоорондын зөрүүг харуулж байна.

Засгийн газар 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдөр 151 тоот тогтоол гарган, “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг баталжээ.

Уг журмын 12 дугаар зүйлд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын хэрэгжилтэд нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага, геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хяналт тавина гэж заасан байна. Эдгээр байгууллагын бүрэн эрхийг тус бүрд нь авч үзвэл:

- Аймаг, нийслэлийн Засаг дарга нь бичил уурхайн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, ялангуяа бичил уурхайн нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэгтэй. Энд бичил уурхайн “нөхөн сэргээлтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах” үүрэг нь хяналтын чиглэлээрх бусад байгууллагын уялдаа холбоог хангах агуулгаар ойлгогдож байна.
- Түүнчлэн сум, дүүргийн Засаг дарга нь бичил уурхай эрхлэгч этгээд гэрээгээр тогтоосон талбайд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, бичил уурхайн аюулгүй байдлын дүрмийн хэрэгжилт болон химийн хортой, аюултай бодис, хориглосон химийн бодисын хэрэглээ, хадгалалтад хяналт тавих чиг үүрэгтэй.
- Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэгтэй. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх үүднээс УУХҮЯ болон БОАЖЯ хамтран бичил уурхай эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийдэг боловч эдгээр нь цар хүрээний хувьд хязгаарлагдмал бөгөөд мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай ямар нэг байдлаар давхарддаг байна. Цаашлаад бичил уурхайн нөхөн сэргээлтэд хяналт тавих бүрэн эрх нь төрийн захиргааны дээрх хоёр төв байгууллагад

хадгалагдаж байгаа бол хяналт зохион байгуулах чиг үүрэг нь аймаг, нийслэлийн Засаг даргад хадгалагдаж байна гэж ойлгож болох юм.

1.1.5. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлэх тогтолцоо

БОХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр тусган, бүтцийг тодорхойлжээ. Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум, дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч болон байгаль хамгаалагч тус тус ажиллахаар байна. Мэргэжлийн хяналттай холбоотой БОХТХ-ийн зохицуулалтыг судалгааны Хавсралт 3-аас авч үзнэ үү.

Мөн хуулиар мэргэжлийн хяналтын байгууллагаас гадна орон нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын хяналтын чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ.⁸ Аймаг, нийслэлийн болон сум, дүүргийн Засаг дарга нь:

- Нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавих;
- Илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;
- Шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй байна.

⁸ БОХТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2.4 болон 17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалт.

Ийнхүү Засаг даргын хяналтын бүрэн эрхийг илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол үйл ажиллагааг түдгэлзүүлэн зогсоох зэрэг өргөн хүрээнд тодорхойлжээ.⁹

Энэхүү зохицуулалтын хүрээнд Дорнод аймгийн Засаг дарга 2017 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр А/435 тоот захирамж гарган, БОХтХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх хэсгийг үндэслэл болгон “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн газрын тос тээвэрлэх үйл ажиллагааг зогсоож байжээ. Хэдийгээр бусад аймгийн хувьд энэ талаарх мэдээлэл хомс байгаа боловч Дорнод аймгийн энэхүү жишээ нь аймгууд тус хуулийн зохицуулалтыг ашиглан зөрчил гаргасан аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр зогсоох зэрэг арга хэмжээ авах боломжтойг харуулж байна.

*Дорнод аймгийн МОНЦАМЭ агентлагийн
мэдээллийн эх сурвалжаас*

1.1.6. Уул уурхайн салбарт байгаль орчны хяналт хэрэгжүүлэх субъект

Дээр дурдсан зохицуулалтаас гадна 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн долоодугаар бүлэгт байгаль орчин, амьтан, ургамал, тусгай хамгаалалттай газар нутгийг хамгаалахтай холбоотой 16 хууль зөрчсөн тодорхой үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцон хариуцлага хүлээлгэхээр тусгажээ.

Зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон зөрчлийг хянан шалгахтай холбоотой харилцааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (ЗШШтХ)-иар зохицуулдаг. ЗШШтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.10-т зааснаар *мэргэжлийн хяналтын улсын байцаагч* байгаль орчны холбогдолтой нийт 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх¹⁰ ба *татварын улсын байцаагч* агаарын бохирдлын төлбөрийн тухай болон

⁹ БОХтХ-иар тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоотой холбоотой зохицуулалтыг энэхүү тайлангийн Хавсралт 3-аас харна уу.

¹⁰ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг.

ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүйтэй холбоотой зөрчлийг¹¹ хянан шалгах эрхтэй байна. Харин *цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч* Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15.8-д заасан усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, машин техник, бохир зүйл угаасан, усны нөөц бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй зөрчлийг шалган шийдвэрлэнэ. Мөн *улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч* нь ургамлын өвчин, хөнөөлт шавж, мэрэгч амьтан, хог ургамал устгах ажил гүйцэтгэсэн талбайд хорионы хугацаа дуусаагүй байхад аж ахуйн эсхүл бусад үйл ажиллагаа явуулж ургамал, хорио цээрийн дэглэм зөрчсөн,¹² ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан,¹³ усны тухай хууль зөрчсөн,¹⁴ зөвшөөрөлгүйгээр эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн,¹⁵ тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулсан зөрчилд¹⁶ тус тус хянан шалгах ажиллагаа явуулахаар харьяалал тогтоосон байна.¹⁷

ТХШТХ, АМТХ, ТТАМТХ, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам, БОХТХ болон Зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон хяналт шалгалтын тогтолцоог авч үзвэл төрийн хяналтыг хэрэгжүүлэх гол байгууллага нь мэргэжлийн хяналтын байгууллага байна. Харин бусад байгууллага, тухайлбал, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд хяналт тавих ерөнхий эрх хэмжээг хэрэгжүүлэхээр байна. Уул уурхайн үйл ажиллагаанд байгаль орчны хяналт тавих тогтолцоог хууль тогтоомжоор хэрхэн тодорхойлсныг Хүснэгт 1-д харуулав.

¹¹ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.16.3 дахь заалт.

¹² Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийг 7.8.2 дахь заалт.

¹³ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9.5 дахь заалт.

¹⁴ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.15 дахь хэсэг.

¹⁵ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.16.2 дахь заалт.

¹⁶ Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.17 дахь хэсэг.

¹⁷ Зөрчлийн тухай хуулиар тодорхойлсон зөрчил шалган шийдвэрлэх харьяаллыг Хавсралт 4-өөс харна уу.

*Хүснэгт 1. Уул уурхайн салбар дахь байгаль орчны
хяналтын тогтолоцоо*

Хуулийн нэр	Хяналт хэрэгжүүлэгч үндсэн субъект	Бусад субъектийн талаарх тодруулга
<i>Ашигт малтмалын тухай хууль</i>	Ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.	Ашигт малтмалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага нь хяналт тавих эрхтэй. Гэхдээ эдгээр байгууллагын хяналтын бүрэн эрх нь ТХШтХ-д зааснаас явцуу хүрээтэй төдийгүй бүрэн эрхээ хэрэгжүүлэх үйл явцыг журамлаагүй байна.
<i>Түгээмэл тархац-тай ашигт малтмалын тухай хууль</i>	Улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлнэ.	Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь хуульд заасан зарим асуудлын хүрээнд хяналт тавих эрхтэй.
<i>Байгаль орчныг хамгаалах тухай хууль</i>	Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн байгаль орчныг хамгаалах үүргийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын байгууллага ба аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина. Засаг дарга нь илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах эрхтэй.	Байгаль орчны чиглэлээр төрийн хяналт хэрэгжүүлэх бусад субъектийн эрх хэмжээг мэргэжлийн хяналтын байгууллагынхаас ялгаатай байдлаар тодорхойлоогүй.

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

<i>Зөрчлийн тухай хууль</i>	Зөрчлийн тухай хуулийн долоодугаар бүлэгт заасан байгаль орчныг хамгаалах, бохирдуулах, хууль бус үйл ажиллагаа явуулахтай холбоотой зөрчлийг шалган шийдвэрлэх субъект нь байгаль орчны улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч болон цагдаагийн эрх бүхий албан тушаалтан буюу экологийн цагдаагийн албаны зөрчил хариуцсан мөрдөн байцаагч байна.	Зөрчлийн тухай хуульд уул уурхайн компаниудын зүгээс гаргасан зөрчлийг шалган шийдвэрлэх харьяаллыг давхардуулсан буюу цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч, улсын байцаагчийн эрхтэй давхардсан, мөн байгаль хамгаалагчийн шалган шийдвэрлэх зөрчлийн харьяаллыг мэргэжлийн хяналтын улсын байцаагчийнхтай давхардуулан тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйлийн 2 дахь, 7.9 дүгээр зүйлийн 5 дахь, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 2 дахь, 7.15 дугаар зүйл болон 7.17 дугаар зүйлийн 8 дахь хэсгүүдэд заасан зөрчлийг хоёр өөр субъект аль аль нь шалган шийдвэрлэх боломжтой байна.
-----------------------------	--	--

1.1.7. Хяналт хэрэгжүүлэгч субъектийг тодорхойлохтой холбоотой практикийн зарим асуудал

Ийнхүү уул уурхайн салбарт төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх үндсэн субъект болох мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүргийг өөр олон байгууллага, албан тушаалтныхтай давхцуулан тодорхойлсон нь практикт зөрчил үүсгэн, хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна.

Хууль хэрэглээний хамгийн эхний асуудал нь мэргэжлийн хяналтаас бусад эрх бүхий байгууллагын “хяналт тавих эрх” хэт ерөнхий байдлаар томъёологдсон, уг эрхийг хэрэгжүүлэхдээ ямар арга хэмжээ авах, ямар журам баримтлах нь тодорхойгүй байгаа явдал юм. Түүнчлэн

БОХТХ-иар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь хяналт тавих, цаашлаад зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах эрхтэй боловч “зөрчил арилгуулах арга хэмжээ” гэдэгт юуг ойлгохыг тодорхойлоогүй байна. Ингэснээр энэхүү заалтыг практикт янз бүрээр тайлбарлан хэрэглэх эсвэл огт хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүрч байгаа нь ярилцлагын явцад ажиглагдлаа.

Аймаг, орон нутаг дахь мэргэжлийн хяналтын газар, байгаль орчин, аялал жуулчлалын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар, экологийн цагдаагийн алба зэрэг байгууллага хамтран “нэгдсэн хяналт шалгалт” хийдэг практик 2013 он хүртэл Дундговь аймагт байжээ. Харин Төв аймагт энэ практик өнөөдрийг хүртэл хэрэгжсээр байна. Нэгдсэн хяналт шалгалтын хүрээнд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд тухайн шалгалтын бүрэлдэхүүнд оролцсон бүх байгууллагын төлөөлөгчид шалгалт хийдэг боловч хуулиар бүрэн эрх олгогдсоны дагуу ганцхан мэргэжлийн хяналтын улсын байцаагч дүгнэлт, шийдвэр гаргадаг байна.

Орон нутагт хийсэн ярилцлагаас

Дээр дурдсанчлан олон байгууллага уул уурхайн салбарт аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх эдлэх боловч ямар нэг зөрчил гарсан тохиолдолд зөвхөн мэргэжлийн хяналтын улсын байцаагч эсхүл экологийн цагдаагийн байгууллага л шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах эрхтэй. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч нь ТХШТХ ба ЗШШТХ-ийг, харин экологийн цагдаагийн албаны мөрдөн байцаагч ЗШШТХ-ийг журамлан зөрчлийг шалган шийдвэрлэж байна.

Судалгааны хүрээнд БОАЖЯ, УУХҮЯ болон АМГТГ-ын холбогдох хүмүүстэй уулзаж, ярилцлага хийсэн болно. БОАЖЯ болон АМГТГ-ын хувьд жил бүр урьдчилан төлөвлөсний үндсэн дээр уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд албан бус, төлөвлөгөөт хяналт шалгалт хийдэг байна. Тухайлбал, АМГТГ-ын хувьд агентлагийн даргын

баталсан удирдамжийн дагуу “албан бус” төлөвлөгөөт шалгалтыг бүсчилсэн байдлаар (төв, говь, баруун болон зүүн бүс) зохион байгуулдаг. Энэхүү “албан бус” шалгалт нь хяналт шалгалт гэхээсээ илүү аж ахуйн нэгжүүдэд зөвлөн туслах зорилготой байдаг ажээ. Мөн АМГТГ-ын зүгээс “албан бус” хяналт шалгалтад зориулан нийт 29 зүйл бүхий шалгах хуудсыг дотоодынхоо хэрэгцээнд зориулан баталжээ. Хяналт шалгалтын үр дүнд илрүүлсэн зөрчлийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад хүргүүлснээр уг ажиллагаа дуусгавар болдог байна.

БОАЖЯ-ны хувьд МХЕГ, экологийн цагдаагийн албатай гэрээ байгуулж, мэдээлэл солилцон, хамтран ажилладаг бөгөөд хамтарсан шалгалтын төлөвлөгөөг судалгаанд үндэслэн өмнөх оны төгсгөлд гаргадаг. Энэхүү хамтарсан шалгалт нь мэргэжлийн хяналтын байгууллагын жил бүрийн төлөвлөгөөт хяналт шалгалтаас тусдаа хийгддэг байна.

БОАЖЯ, УУХҮЯ болон АМГТГ-ын хувьд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн хууль зөрчсөн үйл ажиллагаатай холбоотой гомдол, мэдээлэл хүлээн авсан бол МХЕГ, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт уламжлан, шаардлагатай тохиолдолд иргэдээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулж хяналт шалгалт явуулдаг. Шалгалтын үр дүнг илтгэх хуудас бэлтгэн тухайн ажлын хэсэгт ажиллаж буй мэргэжлийн хяналтын улсын байцаагчид хүргүүлж, дүгнэлт, албан шаардлагад нь тусгуулдаг.

Мэргэжлийн хяналтын байгууллагаас бусад төрийн байгууллага нь хяналтын чиг үүрэгтэйгээс бус, шалгах эрх хуулиар олгогдоогүй. Харин энэ талаар иргэд, аж ахуйн нэгж мэдээлэл хомс байдгаас ихэнх тохиолдолд гомдол, мэдээллийг тухайн асуудал хариуцсан орон нутгийн захиргааны байгууллага эсхүл хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох яаманд ирүүлдэг. Гэтэл тухайн байгууллагууд нь шалгалт хийх эрхгүй тул мэргэжлийн хяналтын байгууллагад албан бичгээр тухайн өргөдөл, гомдол, мэдээллийн талаар мэдэгддэг. Энэ нь иргэдийн өргөдөл, гомдлын дагуу түргэн шуурхай арга хэмжээ авах, хяналт шалгалт хийх боломжгүй болгох, үүний улмаас иргэдийн зүгээс “Төрийн алба хүнд сурталтай, цаг тухайд нь арга хэмжээ авдаггүй” гэх зэрэг шүүмжлэлд өртөхөд хүргэдэг бөгөөд энэхүү хүндрэл бэрхшээлийг арилгах зайлшгүй шаардлагатай байгаа.

Төрийн захиргааны төв болон захиргааны байгууллагуудын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Ийнхүү төрийн захиргааны байгууллагуудаас хийж байгаа хяналт шалгалт нь нэг талаас хуулиар олгосон эрхийн хүрээнд тодорхой асуудлаар “хяналт тавих” бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа явдал боловч нөгөө талаас мэргэжлийн хяналтын улсын байцаагчид мэргэжил, арга зүйн чиглэлээр зөвлөн тусалдаг гэж үзэж болохоор байна.

Экологийн цагдаагийн алба нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 тоот тогтоолоор байгуулагджээ.¹⁸ Тус алба нь Монгол Улсад хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, байгаль экологид учрах хохирлыг бууруулах нэгдсэн бодлого хэрэгжүүлэх үндсэн зорилготой нэгж юм. Экологийн цагдаагийн албаны хувьд өнөөдрийн байдлаар Монгол Улсын 65 суманд мөрдөн байцаагчтай бөгөөд ЗШШТХ-ийн хүрээнд Зөрчлийн тухай хуулийн зөвхөн 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг буюу усны

¹⁸ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Цагдаагийн төв байгууллагын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай” 03 тоот тогтоол.

сан бүхий газарт хог хаягдал хаясан эсхүл машин техник, бохир зүйл угаасан эсхүл усны нөөц бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй зөрчлийг л шалган шийдвэрлэх эрхтэй байна. Харин практикт уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчид болон хувь хүмүүсийн зүгээс АМтХ, БОХтХ, Зөрчлийн тухай хууль болон бусад хуулийг зөрчих явдал элбэг гардаг бөгөөд тухай бүр хойшлуулшгүй ажиллагааны журмаар шалган шийдвэрлэх шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд экологийн цагдаа нь зөрчлийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад албан тоотоор хүргүүлэхээс өөр арга хэмжээ авч чаддаггүй байна.


Дээр дурдсанаас үзэхэд төрийн байгууллагуудын хяналтын чиг үүрэг давхардсан, хяналт хэрэгжүүлэх үйл явцыг нарийн журамлаагүйгээс хяналтын чиг үүргээ хэтрүүлэн хяналт шалгалт зохион байгуулах тохиолдол түгээмэл байна. Мөн зөрчил арилгуулах, зөрчилд холбогдуулан захиргааны акт гаргах эрхгүй тул мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн оролцоотой ажлын хэсэг байгуулах эсхүл зөрчлийн мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлдэг практик тогтжээ.

1.2. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

1.2.1. Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тогтоосон мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо

ТХШтХ-ийн есдүгээр зүйлд мэргэжлийн хяналтын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх бөгөөд мэргэжлийн хяналтын төв байгууллага, аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, хилийн мэргэжлийн хяналтын алба, сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас бүрдсэн босоо тогтолцоотой байхаар тусгасан.

Схем 1. ТХШтХ-иар тогтоосон мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо



Томилох бүрэн эрх

Мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга буюу улсын ерөнхий байцаагчийг Монгол Улсын Ерөнхий сайд томилж, чөлөөлөх; мэргэжлийн хяналт хэрэгжүүлэх орон нутгийн байгууллагын даргыг Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулж¹⁹, аймаг, нийслэлийн Засаг даргатай зөвшилцсөний үндсэн дээр мэргэжлийн хяналтын төв байгууллагын дарга²⁰ тус тус томилно. Мөн орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын улсын байцаагчийг тухайн орон нутаг дахь улсын ахлах байцаагч томилж, чөлөөлнө.

Харин мэргэжлийн хяналтын төв байгууллагад ажиллах салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч болон улсын байцаагч нарт МХЕГ-ын дарга улсын байцаагчийн эрх олгоно. Гэхдээ МХЕГ-ын дарга нь тэдгээрт зөвхөн байцаагчийн эрх олгох бөгөөд харин томилгооны асуудал нь зохицуулагдаагүй үлдсэн байна.²¹

¹⁹ ТХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.11 дэх хэсэг.

²⁰ ТХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсэг.

²¹ Төрийн албаны тухай хуулийн дагуу тухайн орон нутаг дахь Төрийн албаны салбар зөвлөлөөс мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн сонгон шалгаруулалт зарладаг.

Улсын байцаагчийн эрх олгох

ТХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллах салбарын улсын байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчдад улсын ерөнхий байцаагч буюу МХЕГ-ын дарга улсын байцаагчийн эрх олгохоор тусгасан. Цаашилбал МХЕГ-ын даргад улсын байцаагчийн эрхийг Засгийн газар олгохоор ТХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.3-г заажээ. Харин орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагад ажиллах бүсийн улсын ахлах байцаагчийн эрхийг хэрхэн, яаж олгох зохицуулалт байхгүй байна.

1.2.2. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар тогтоосон мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо

БОХтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр тусгаж, 26.3 дахь хэсэгт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв болон аймаг, нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын бүтцийг тодорхойлжээ. Тус хуульд зааснаар мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, харин аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.

Хүснэгт 2. Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагад ажиллах улсын байцаагчийн талаарх ТХШтХ болон БОХтХ дахь зохицуулалт

Хуулийн зүйл, заалт/ байгууллага	ТХШтХ-ийн 10.1 дэх заалт	БОХтХ-ийн 26.3
Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллага	<ul style="list-style-type: none"> - Улсын ерөнхий байцаагч - Салбарын улсын ерөнхий байцаагч - Улсын ахлах байцаагч - Улсын байцаагч 	<ul style="list-style-type: none"> - Улсын ерөнхий байцаагч - Салбарын улсын ерөнхий байцаагч - Улсын ахлах байцаагч
Мэргэжлийн хяналтын орон нутгийн байгууллага	<ul style="list-style-type: none"> - Бүсийн улсын ахлах байцаагч - Улсын ахлах байцаагч - Улсын байцаагч 	<p>Аймаг, нийслэлд:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын ахлах байцаагч - Улсын байцаагч <p>Сум, дүүрэгт:</p> <ul style="list-style-type: none"> - Улсын ахлах байцаагч - Улсын байцаагч - Байгаль хамгаалагч

Хүснэгтээс харахад уул уурхайтай холбоотой байгаль орчны асуудлаар хяналт хэрэгжүүлэх мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын тогтолцоог зохицуулсан ТХШтХ болон БОХтХ-ийн заалтууд хоорондоо зөрүүтэй байна. Өөрөөр хэлбэл, БОХтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3-т Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын бүтцэд улсын байцаагч байхгүй, аймаг, нийслэлд салбарын улсын ерөнхий байцаагч эсхүл бүсийн улсын ахлах байцаагч ажиллахааргүй, харин сум, дүүрэгт байгаль хамгаалагч ажиллахаар заасан нь ТХШтХ-ийн зохицуулалтаас ялгаатай байна.

Цаашилбал БОХтХ-ийн 26 дугаар зүйлийн 26.4.1-д “Улсын байцаагчийг дараах байдлаар томилж, чөлөөлнө гээд улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг ТХШтХ-ийн 10.4 дэх хэсэгт заасны дагуу олгоно”

гэсэн нь тухайн хэсгийн зорилгоос гажсан буюу томилгооны асуудал бус, байцаагчид эрх олгох асуудлыг зохицуулжээ.

Хэдийгээр сумын байгаль орчны улсын байцаагч нь ТХШТХ-иар мэргэжлийн хяналтын байгууллагын босоо тогтолцоонд хамаарах боловч түүнийг сумын Засаг даргын Тамгын газраас томилдог ба ийнхүү томилохдоо сумын Засаг даргын Тамгын газрын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилдог аж.

Төв аймагт хийсэн ярилцлагын судалгаанд оролцогчийг сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчаар ажиллаж байсныг нь Төрийн албаны зөвлөлөөс шаардсаны дагуу байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн болгож өөрчилжээ. Гэхдээ улсын байцаагчийн эрх нь өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр байна. Ийнхүү сумын түвшинд бодлого хэрэгжүүлэх болон хэрэгжилтэд хяналт тавих гэсэн харилцан адилгүй хоёр чиг үүргийг нэг албан тушаалтан хэрэгжүүлж байгаа нь хяналтын үр нөлөөг бууруулахаас гадна тогтолцооны хувьд гажуудал үүссэнийг харуулж байна.

Сумын улсын байцаагчтай хийсэн ярилцлагаас

Мөн БОХТХ-ийн 26.4.4-т заасны дагуу байгаль хамгаалагчийг сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга томилно. Энэ нь мэргэжлийн хяналтын байгууллага нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг зөрчсөн бөгөөд байгаль хамгаалагч эргээд ажлаа мэргэжлийн хяналтын байгууллагад бус Засаг даргад тайлагнадаг нь байгаль хамгаалагчийг мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцооноос бүрмөсөн тусгаарлажээ. Өөрөөр хэлбэл, БОХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.3-т зааснаар байгаль хамгаалагч нь сум, дүүрэгт мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх субъект байхаар тусгасан байх боловч түүнийг Засаг дарга дангаараа томилдог нь тогтолцооны гажуудал үүсгэсэн гэж үзэж болохоор байна. Нөгөө талаас байгаль хамгаалагчийг тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтцэд хамааруулан, уг газраас томилж,

чөлөөлөх практик бас байна. Энэ нь байгаль хамгаалагчийн орон тоог аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын бүтцэд хамааруулдаг, сум, дүүргийн Засаг даргын төсөвт байгаль хамгаалагчийн цалин суудаггүйтэй холбоотой болохыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын төлөөлөл ярилцлагадаа дурдсан юм.

Ийнхүү байгаль хамгаалагч болон сумын байгаль орчны хяналтын улсын байцаагчийг томилох нэгдсэн тогтолцоо, нэг жишиг байхгүй учраас аймаг бүр уг үйл ажиллагааг ялгаатай байдлаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршсан байгаль хамгаалагчийн ажлын байрны тодорхойлолт болон сул орон тооны зарлалаас харахад зарим тохиолдолд сумын Засаг даргын Тамгын газар (Дорнод болон Орхон аймгийн бүх сум²²), Хэнтий, Говьсүмбэр, Төв, Баян-Өлгий зэрэг аймагт Байгаль орчин, аялал жуулчлалын газар томилж байна.

Сумын байгаль хамгаалагч, байгаль орчны улсын байцаагчтай холбогдуулан анхаарвал зохих өөр нэг зүйл нь зэрэг дэв, цалингийн асуудал юм. Төрийн албаны тухай хуулийн 18-р зүйлийн 18.8-д “Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэлийг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу Засгийн газар болон Төрийн албаны зөвлөлөөс оруулсан саналын дагуу Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг баталсан байна. Тус журмын дагуу сумын байгаль орчны улсын байцаагч нь зэрэг дэвийн хувьд дэс түшмэл буюу цалингийн шатлалын хувьд ТЗ-2²³ бүлэгт хамаарч байна. Гэтэл мэргэжлийн хяналтын байгууллагын байцаагч нь тус журмын дагуу эрхэлсэн түшмэл эсхүл ахлах түшмэл гэсэн зэрэг дэвтэй, цалингийн

²² Гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зар, Дорнод аймгийн Матад сум, 2020 оны 6 дугаар сарын 11-ний өдөр. Төрийн албаны албан ёсны вэбсайтаас харах боломжтой.

<http://www.csc.gov.mn/s/35/534>

²³ Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн систем, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472-р тогтоол, 2-р хавсралт.

шатлалын ТЗ-6²⁴ бүлэгт хамаарч байна. Өөрөөр хэлбэл, сумын байгаль орчны улсын байцаагч нь хэдийгээр мэргэжлийн хяналтын ерөнхий газраас олгосон эрхийн хүрээнд үүрэг гүйцэтгэдэг боловч сумын Засаг дарга томилдог учир мэргэжлийн хяналтын байцаагчаас доогуур зэрэг дэв, цалингийн шатлалд хамаарч байна. Энэ нь тэдний хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болохыг судалгаанд оролцогч сумын байцаагч онцолж байсан юм.

Түүнчлэн ЗШШТХ-иар зарим зөрчлийг улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч болон мэргэжлийн хяналтын улсын байцаагчид давхардуулан харьяалуулсан²⁵ тул практикт аймгууд өөрсдийн түвшинд зохицуулалт хийж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчгүй эсхүл байцаагчийн эзгүйд байгаль хамгаалагч уг зөрчлүүдийг шалган шийдвэрлэж, бусад үед тухайн зөрчлийг зөвхөн мэргэжлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэж байна.

Түүнчлэн судалгааны 1.1.7-д дурдсанчлан орон нутагт хийгдэх хамтарсан шалгалт нь ТХШТХ-ийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан хяналт шалгалтын бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус, мэргэжлийн бусад байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, иргэнийг татан оролцуулж болно гэсний дагуу хийгдэж байгаа боловч шалгалтын удирдамжийг нь Засаг дарга баталдаг асуудлыг хуульд нийцүүлэх шаардлагатай юм.

Дээр дурдсаныг дүгнэвэл БОХТХ-иар мэргэжлийн хяналтын тогтолцоог ТХШТХ-иас зөрүүтэй хуульчлан, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)-т улсын байцаагч ажиллахгүй байхаар тусгажээ. Гэтэл практикт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газарт улсын хоёр байцаагч ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчийн асуудал дээр БОХТХ-ийг биш, харин ТХШТХ-ийг удирдлага болгодог байна. Харин эсрэгээрээ сум, дүүрэгт ажиллаж байгаа байгаль хамгаалагчийн асуудал дээр ТХШТХ-ийг биш, харин БОХТХ-ийг баримталдаг ажээ.

²⁴ Мөн тэнд.

²⁵ Хүснэгт 1-ээс харна уу.

Ийнхүү мэргэжлийн хяналтын байгууллагын бүтцийг хоёр өөр хуулиар давхардуулан зохицуулсан нь эрх зүйн хийдэл, зөрчил үүсгэж байна. Хууль зүйн талаасаа БОХТХ-иар тодорхойлсон улсын байцаагчтай холбоотой зохицуулалтыг зөвхөн мэргэжлийн хяналтын байгууллагын байгаль орчны хяналтын бүтцэд хамааруулан авч үзэж болох юм. Энэ тохиолдолд БОХТХ-ийн 26 дугаар зүйлийн 3 дахь заалтын дагуу МХЕГ-т байгаль орчны хяналтын улсын байцаагч ажиллуулахгүй, зөвхөн улсын ахлах байцаагч ажиллуулж болох юм.

ХОЁР. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Төрийн хяналт шалгалтын үр нөлөөнд дүн шинжилгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах, судлах аргачлал”-ын 6-р бүлэгт заасан шалгуур үзүүлэлтүүдийг удирдлага болгов. Тус аргачлалд аливаа хууль тогтоомжийн зохицуулалтын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтээр шалган судлахаар заажээ. Үүнд:

- Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө;
- Эдийн засагт үзүүлэх үр нөлөө;
- Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал.

Уул уурхайн салбарт байгаль орчны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, түүний үр нөлөөг тодорхойлох нь энэхүү судалгааны үндсэн судлагдахуун болно. Иймээс байгаль орчинд үзүүлэх үр нөлөө болон байгаль орчны сөрөг нөлөөллийн улмаас эрх нь зөрчигдөж буй иргэн, хүн амын нийтлэг эрхийг хамгаалах нөхцөлийг хэрхэн бүрдүүлж байгааг шинжлэх болно.

Улс орны түүхээс харахад уул уурхайн салбар нь байгаль орчинд сөргөөр нөлөөлж, хүн амыг шилжин суурьшихад хүргэснээр эдийн засаг, нийгмийн тэгш бус байдлыг өдөөн, зэвсэгт мөргөлдөөнд хүргэж байсан сургамжууд цөөнгүй байдаг. Иймээс түүхий эдээс хамааралтай

эдийн засаг болон дотоодын нийт бүтээгдэхүүний харилцан хамаарлын талаар олон судалгаа хийгдэж, үүнээс үүссэн сөрөг хамаарлыг “Баялгийн хараал” гэж нэрлэх болжээ.

Ийнхүү байгаль орчны бохирдол, нийгмийн бүтцэд үзүүлж байгаа сөрөг нөлөөллөөс шалтгаалан уул уурхайг асуудалтай салбар гэж үзэх болжээ.²⁶ Уул уурхайн үйл ажиллагааны явцад газарзүйн байршлаас үл хамааран байгаль орчин, нийгмийн бүтэц өөрчлөгдөхөөс гадна газар нутгийн байгалийн тогтоц, экологийн бүтцэд ч томоохон өөрчлөлт орж, тэрхүү өөрчлөлтийн үр дагавар нь тухайн нутгийн иргэдэд хамгийн хүндээр нөлөөлдөг.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т заасан Монгол Улсын иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах гол нөхцөл нь уул уурхайн салбарын сөрөг нөлөөллийг бууруулж, байгаль орчинд ээлтэй технологийг зөв ашиглах явдал юм. Үүнд хяналт шалгалт нэн чухал бөгөөд төрийн хяналт шалгалтыг ТХШТХ-д заасны дагуу “Хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн болон орчны аюулгүй байдал нь бусад аливаа сонирхол, зорилгоос илүүд байх” зарчмыг баримтлан хэрэгжүүлж, түүний үр нөлөөг тогтмол үнэлж байх нь зүйтэй.

2.2. УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд ашигт малтмалын хайгуулын нийт 987 тусгай зөвшөөрөл, ашиглалтын 1,675 тусгай зөвшөөрөл бүртгэлтэй байна.²⁷ Мэргэжлийн хяналтын байгууллагын уул уурхайн салбарт явуулж байгаа үйл ажиллагааны статистик мэдээллийг үзвэл 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр хүртэл МХЕГ болон аймгуудын мэргэжлийн хяналтын газруудын зүгээс нийт 2,130 төлөвлөгөөт хяналт шалгалт явуулсан байна.²⁸

²⁶ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, “Хариуцлагатай уул уурхай” гарын авлага, УБ., 2016.

²⁷ АМГТГ-ын статистик мэдээ.

<https://www.mrpm.gov.mn/article/55/>. 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр нэвтэрсэн.

²⁸ Шилэн дансны цахим хуудас.

<http://khyanal.gov.mn/portal/inspectedEntity>. 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр нэвтэрсэн.

Гэвч Шилэн дансны цахим хуудаснаас харахад дээрх хугацаанд төлөвлөгөөт бус шалгалт буюу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд хийгддэг хяналт шалгалт огт хийгдээгүй харагдаж байгаа нь сонирхол татаж байна. Мөн хугацаанд 820 гүйцэтгэлийн хяналт шалгалт хийсэн байна.²⁹

Ийнхүү мэргэжлийн хяналтын байгууллагаас хяналт шалгалтыг тухай бүр хийж байгаа боловч Монгол Улсын хэмжээнд 1,643 байршилд 1,941 эвдэрсэн газар байгаа бөгөөд түүнээс 938 нь уул уурхайн олборлолтоос үүдэлтэй байгаа нь хяналт шалгалтын үр нөлөөнд анхаарал хандуулах шаардлагатайг илтгэж байна.³⁰ Тэрчлэн эвдрэлд орж орхигдсон 2,743 га газар байгаа³¹ бол нөхөн сэргээлт хийгдсэн талбайн хэмжээ 2017-2018 онд 1840.79 га, 2018-2019 онд 1873.7 га байснаа 2019-2020 онд 92.72 га болж буурсан нь Ковид-19 цар тахлаас шалтгаалсан байж болзошгүй юм.³²

Хэдийгээр эвдрэлд орж орхигдсон газрын тоог Монгол Улсын хэмжээнд олон жилийн хугацаанд эвдэрч орхигдсон газруудыг тоолох байдлаар гаргасан боловч энэ нь 2003 онд ТХШТХ батлагдсанаас хойших хугацаанд хийгдсэн мэргэжлийн хяналт шалгалтын үр нөлөөтэй тодорхой хамааралтай юм.

Түүнчлэн мэргэжлийн хяналтын байгууллагаас уул уурхайн хайгуул, олборлолттой холбоотой 3,001 зөрчлийг илрүүлж, түүнээс 2020 оны эхний 10 сарын байдлаар 274-д нь арга хэмжээ авсан ажээ.³³ Харин яг

²⁹ Мөн тэнд.

³⁰ Эвдэрсэн газрын мэдээллийн сан.
<https://eic.mn/dlid/inventorydata.php?count=10>. 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр нэвтэрсэн.

³¹ Эвдэрсэн газрын мэдээллийн сан.
<https://eic.mn/dlid/statistics.php?id=2> 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр нэвтэрсэн.

³² Эвдэрсэн газрын мэдээллийн сан.
<https://eic.mn/dlid/statistics.php?id=2> 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар.

³³ Шилэн хяналтын цахим хуудас.
<http://khyanal.gov.mn/statistic> 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар.

ямар зөрчилд ямар арга хэмжээ авсан, тэдгээрийн хэд нь хэрэгжсэн талаарх статистик мэдээлэл байхгүй байна.

Иймд энэхүү тайлангийн дараагийн хэсэгт мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын үр нөлөөнд хамаарах хүчин зүйлийг авч үзлээ.

2.3. УУЛ УУРХАЙН САЛБАРТ МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

2.3.1. Хяналт шалгалтын тогтолцоо нь хяналт шалгалтын үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь

Энэхүү тайлангийн нэгдүгээр бүлэгт уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын тогтолцоог авч үзсэн билээ. Хэдийгээр салбарын гол хуулиудаар улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага хэрэгжүүлэхээр холбогдох хуульд заасан боловч салбарын хуулиудаар яам, агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагад хяналтын тодорхой эрх олгосон байдаг. Иймд дээрх байгууллагууд уг хяналтын эрхээ хэрэгжүүлэх үүднээс жил бүр ажлын хэсэг байгуулах замаар сайдын эсхүл тухайн агентлагийн даргын баталсан удирдамжийн хүрээнд “албан бус” төлөвлөгөөт хяналт шалгалт хийдэг. Мөн иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээлэлд үндэслэн төлөвлөгөөт бус шалгалтыг мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулан явуулдаг практик тогтжээ.

ТХШТХ-ийн 5 дугаар зүйлд зааснаар мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагаас дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээг харгалзан мэргэжлийн хяналтын төв байгууллага өмнөх жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор баталж, олон нийтэд мэдээлдэг. Харин төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд хийдэг. Энэ тохиолдолд таваас доошгүй хоногийн өмнө тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэх журамтай.

АМГТГ-ын хувьд жил бүр хийдэг “албан бус” төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийг тус газрын дарга баталдаг бол хамтарсан ажлын хэсгийн хувьд удирдамжийг сайд баталдаг.

Ийнхүү УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ болоод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хуулиар хяналт шалгалт хийх бүрэн эрх олгогдоогүй, өөрсдийн зүгээс хийж буй “албан бус” хяналт шалгалтын үр дүнд илэрсэн зөрчилд ямар нэг арга хэмжээ авах, захиргааны акт гаргах эрхгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг байна. Гэсэн ч компаниудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх нэрийдлээр дангаар болон хамтран шалгалт хийдэг нь хяналт тавих эрхээ хэтрүүлж буй явдал юм. Энэ нь уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд дарамт, чирэгдэл учруулахаас гадна мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс хэрэгжүүлж буй хяналт шалгалтын үр нөлөөг бууруулдаг байна. Судалгаанд хамрагдсан ихэнх аж ахуйн нэгж хяналт, шалгалтын давхардал нь тэдгээрийн үйл ажиллагаанд чирэгдэл учруулдаг гэж үзжээ.

Цаашлаад хяналт шалгалт хийх эрхгүй этгээдийн цуглуулсан нотлох баримт, материалыг үндэслэн мэргэжлийн хяналтын улсын байцаагч шууд дүгнэлт бичих, акт, албан шаардлага гаргах боломжгүй тул бусад байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус шалгалтыг дахин хийх шаардлага үүснэ. Нэг талаас ийнхүү бусад байгууллага, албан тушаалтнуудын зүгээс хийсэн хяналт шалгалт нь төлөвлөгөөт бус шалгалт хийх үндэслэл болж, мэргэжлийн хяналтын байгууллагыг мэдээллээр хангаж байгаа боловч нөгөө талаас дахин дахин шалгалт хийж аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд төвөг, чирэгдэл учруулах шалтгаан болдог ажээ. Ийнхүү давхар давхар шалгалт хийж буй нь ТХШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д заасан хяналт шалгалтыг давхардуулахгүй байх үндсэн зарчимтай зөрчилдөж байгааг онцлох нь зүйтэй юм.

Ашигт малтмал, газрын тосны газрын хувьд дотооддоо хэрэглэдэг шалгах хуудасны хүрээнд зөвлөн туслах чиг үүргээ хэрэгжүүлэх үүднээс шалгалт хийж, илрүүлсэн зөрчлийг баримтжуулан мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлдэг.

АМГТГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Ийнхүү хяналт шалгалтыг давхардуулах нь маш их баримт бичиг боловсруулах, цаг хугацаа алдах, хүний нөөцийн хуваарилалт хийх нэмэлт ачааллыг компанид үүсгэж, хэвийн үйл ажиллагаанд нь саад болохоос гадна хуулийг буруу тайлбарлах, хэрэглэх зэргээр тухайн шалгалт хийж буй мэргэжилтний ур чадвараас хамаарсан асуудал үүсдэг байна. Зарим тохиолдолд хуульд нийцээгүй янз бүрийн шаардлага тавих, үйл ажиллагааг нь зогсоох зэрэг бэрхшээл үүсгэдэг.

Уул уурхай бүхий сумдад байгаль хамгаалагч нь мэргэжлийн хяналтын байцаагчийн тодорхой эрхүүдийг хэрэгжүүлдэг. БОХТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.3-т заасны дагуу байгаль хамгаалагч нь шаардлага хангасан тохиолдолд байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх олгоно гэж заасан байх боловч (i) байгаль хамгаалагчийг сумын Засаг дарга эсхүл Байгаль орчин, аялал жуулчлалын газраас томилдог; (ii) шаардлага хангаагүй гэх үндэслэлээр улсын байцаагчийн эрх авдаггүй; (iii) байгаль хамгаалагчдад улсын байцаагчийн хэрэгжүүлэх эрхийг хэсэгчлэн олгодог зэрэг нь хяналт шалгалтыг газар дээр нь, үр нөлөөтэй байдлаар хийж гүйцэтгэхэд саад болдог байна. Эдгээрийг задлан тайлбарлавал:

1. Байгаль хамгаалагчийг сумын Засаг дарга эсхүл тухайн аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар томилдог нь байгаль хамгаалагчийн үйл ажиллагаанд томилох эрх бүхий этгээдийн зүгээс нөлөөлөх эсхүл хуулиар тогтоосон шаардлага хангахгүй хүнийг байгаль хамгаалагчаар томилох боломж олгодог. Хамгийн гол нь байгаль хамгаалагчийг мэргэжлийн хяналтын тогтолцооноос бүрэн тусгаарлахад хүргэдэг байна. БОХТХ-ийн 27 дугаар зүйлд зааснаар улсын байцаагч нь байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар

өгөх эрхтэй. Гэхдээ энэхүү эрхийг практикт зөвхөн сургалт зохион байгуулах байдлаар хэрэгжүүлдэг нь учир дутагдалтай юм. Өөрөөр хэлбэл, байгаль хамгаалагчийн чадавх сул гэх асуудал нь нэг талаас тэдгээрийн үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллагаас мэргэжил, арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгдөггүй, БОХТХ-иар мэргэжлийн хяналтын улсын байцаагчид байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх эрх хэмжээгээ бүрэн хэрэгжүүлдэггүйтэй холбоотой. Нөгөө талаас Төрийн албаны салбар зөвлөлөөс байгаль хамгаалагчийг сонгон шалгаруулахдаа бүрэн дунд боловсролтой бол мэргэжил шаардахгүй гэсэн ерөнхий шаардлага тавьдагтай холбоотойгоор дийлэнх тохиолдолд байгаль хамгаалагчдын хууль, эрх зүйн мэдлэг, чадавх сул байдаг. Анкетын судалгааны үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын дийлэнх нь байгаль хамгаалагчийн ур чадвар, чадавхыг хангалтгүй гэж дүгнэсэн байна.

2. ЗШШТХ-иар улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч тодорхой зөрчлүүдийг шалган шийдвэрлэх эрхтэй байдаг. Гэвч суманд томилогдон ажиллаж буй байгаль хамгаалагчид БОХТХ-ийн 26 дугаар зүйлийн 26.5 дахь хэсэгт заасан байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэн байх гэдэг шаардлагыг тэр бүр хангадаггүй. Үүнээс хамааран ихэнх байгаль хамгаалагч байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх авч чаддаггүй байна. Тухайлбал, Төв аймаг 35 байгаль хамгаалагчтайгаас дөрөв нь улсын байцаагчийн эрхтэй байсан бол 2019 оны 12 дугаар сараас хойш улсын байцаагчийн эрхийг нь УМХЕГ-аас сунгаж өгөөгүйн улмаас одоогоор нэг ч байгаль хамгаалагч улсын байцаагчийн эрхгүй байна. Үүнээс шалтгаалан уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийн зүгээс Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан, 7.15 дугаар зүйлд заасан усны тухай хууль зөрчсөн, 7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөвшөөрөлгүйгээр эсхүл зөвшөөрөлгүй цэгт

хаягдал ус нийлүүлсэн болон 7.17 дугаар зүйлд заасан тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулсан зөрчлүүдийг байгаль хамгаалагчийн зүгээс шалган шийдвэрлэх эрхгүй болж, зөрчил илрүүлсэн ч заавал мэргэжлийн хяналтын улсын байцаагчид уламжлах, шилжүүлэх зэргээр цаг хугацаа алддаг. Цаашилбал нотлох баримт алга болох, устах зэрэг эрсдэл үүсэж болзошгүй байна.

3. БОХтХ-ийн 28 дугаар зүйлд зааснаар байгаль хамгаалагч нь хяналт хийхэд шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргуулах (БОХтХ-ийн 27.1.2), хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, ЗШШТХ-д заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох (БОХтХ-ийн 27.1.3) арга хэмжээ авах боломжгүй байдаг. Холбогдох баримт, мэдээллийг аж ахуйн нэгжээс гаргуулан авах нь хяналт шалгалтыг оновчтой хэрэгжүүлэхэд нэн чухал боловч энэхүү эрхийг хэрэгжүүлдэггүй, мөн зөрчлийг арилгахыг шаардах эрх байгаль хамгаалагчид байдаггүй нь тэдний ажлын үр нөлөөг ихээхэн бууруулдаг байна. Нөгөө талаас байгаль хамгаалагч нь хуульд тусгайлан заасан тохиолдолд БОХтХ-ийн 27.1.6-д заасан “...тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж, хэрэгслийг хураах” бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжтой. Гэвч энэхүү заалт нь зөвхөн улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагчид хамаарах ажээ. Ингэснээр байгаль хамгаалагчийн зүгээс тухайн орон нутагтаа байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээхэд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдаг байна.

2.3.2. Хууль тогтоомжийн хийдэл, зөрчил хяналт шалгалтын үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь

- *Хяналт шалгалт хэрэгжүүлэх журмыг тодорхойлон хуульчлаагүй байдал:*

ТХШТХ-ийн 3 дугаар зүйлийн 3¹.1.2-т “Хяналт шалгалтын арга, хэлбэр гэдгийг тухайн шалгалтад хамаарах баримт бичгийг хянан үзэх, шалгуулагч этгээдийн үйл ажиллагаа явуулдаг нутаг дэвсгэр, байр, барилга, байгууламж, өрөө, тасалгаа, тоног төхөөрөмж, бусад объект, тээврийн хэрэгсэл, ачаа бараанд үзлэг хийх, бүтээгдэхүүн болон тухайн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны орчноос дээж авч шинжлэх, турших, учирсан хор хохирол болон гаргасан зөрчлийн хоорондох уялдаа холбоог тогтоох зорилгоор шинжилгээ явуулах зэрэг хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллагын албан тушаалтан, түүнчлэн хууль тогтоомжид заасан журмын дагуу хяналт шалгалтад татагдан оролцож буй шинжээч, шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг...” ойлгоно гэж тодорхойлжээ.

Гэвч ТХШТХ-ийн 5⁵ дахь зүйлээр зөвхөн шинжилгээнд дээж авах журмыг л зохицуулсан байх бөгөөд үзлэг хийх, машин, техник, тоног төхөөрөмжийг хураах, үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зогсоох ажиллагааг хэрхэн хийж гүйцэтгэхийг зохицуулаагүй орхигдуулсан байна. Мөн эдгээр ажиллагааны журмыг МХЕГ-ын даргын 2019 оны А/67 тоот “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага стандарт батлах тухай” тушаалд ч тодорхойлон заагаагүй байна. Ийнхүү Зөрчлийн тухай хуульд хамаарахаас бусад үед хяналт шалгалтын тодорхой ажиллагааг хэрхэн явуулах тухай журмыг хуульчлаагүй нь мэргэжлийн хяналтын байцаагчийн авсан арга хэмжээг хүчингүй болгуулах үндэслэл болдог байна.

- *Зарим тушаал, шийдвэр захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангаагүй болох нь:*

ТХШТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.3.3-т тусгаснаар заасан чиглэл тус бүрээр хяналт шалгалт явуулахтай холбогдсон журам, заавар, маягт, аргачлал, хяналтын хуудас, техникийн ерөнхий шаардлага, эрсдэлийн ангиллыг харгалзан хяналт шалгалт хийх стандарт батлах эрхийг мэргэжлийн хяналтын төв байгууллага эдэлнэ. Үүний дагуу МХЕГ-

ын даргын тушаалаар ”Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага”-ыг тухай бүр баталж иржээ. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандартыг МХЕГ-ын даргын 2019 оны А/67 тоот тушаалаар батлан мөрдөж байна. Гэтэл уг стандартаар хяналт шалгалтын хэлбэрийг шалгалт, урьдчилан сэргийлэх шалгалт, тандалт судалгаа, хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйлчилгээ гэсэн таван төрөлд хуваасан байх боловч эдгээр хэлбэрийг ТХШТХ-иар тодорхойлоогүй байгааг анхаарах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл, хэдийгээр “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага”-ыг стандарт хэлбэрээр зөвхөн байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөх байдлаар баталсан байх боловч энэ нь хууль зүйн талаасаа үйлчлэл нь гадагш чиглэсэн буюу аж ахуйн нэгжүүдийн зүгээс дагаж мөрдөх үүргийг тогтоосон байх тул Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг хангасан байх ёстой.

Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1-д Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуульд нийцсэн байх, 60.1.2-т захиргааны хэм хэмжээний акт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилгын хүрээнд нийцсэн байх, 64.4 дэх хэсэгт Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж бүртгүүлэхээр хүргүүлд гэсэн шаардлагыг захиргааны хэм хэмжээний актад тавьдаг. Гэтэл МХЕГ-ын даргын 2019 оны А/67 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага” стандарт нь дээрх шаардлагыг хангахгүй байгааг онцлон тэмдэглэж байна.

Практикт хууль бус ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагаанд дээрх стандартын хүрээнд урьдчилан сэргийлэх шалгалт хийдэг. Ийнхүү шалгалт хийх зорилго нь зөв боловч хуулиар тодорхойлоогүй урьдчилан сэргийлэх хэлбэрээр хяналт шалгалт хийж байгаа нь учир дутагдалтай юм.

Мөн цаашлаад уул уурхайн салбарыг бүхэлд нь авч үзвэл БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ зэрэг салбарын бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын зүгээс баталсан зарим журмууд

Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангадаггүй тул ХЗДХЯ захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэггүй.

Энэ нь цаашлаад Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ гэсэнтэй зөрчилдөж, тухайн журам, тушаалуудыг хүчин төгөлдөр бус гэж үзэх нөхцөл бүрдүүлж байна. ТХШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “хяналт шалгалтыг зөвхөн хууль болон нийтээр дагаж мөрдөхөөр бүртгэгдсэн эрх зүйн актыг үндэслэн явуулах” гэж заасан байх бөгөөд дээр дурдсанчлан БОАЖЯ, УУХҮЯ, АМГТГ болон МХЕГ-ын зүгээс нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй дүрэм, журмыг үндэслэн хяналт шалгалт явуулж буй нь хяналт шалгалтын үндсэн зарчмыг зөрчиж байна.

- *Хяналт шалгалтын үр дүнд авсан арга хэмжээ, шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тогтолцоо сул:*

Хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж, улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх: ТХШТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.12.2-т аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг акт үйлдэж, улсын орлого болгох, түүнчлэн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх бүрэн эрхийг улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын ахлах байцаагчгүй суманд сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагч тус тус хэрэгжүүлэхээр заасан.

Юуны өмнө “хууль бусаар олсон орлого” гэх ойлголт нь уул уурхайн салбарын хувьд зохих тусгай зөвшөөрөл авалгүйгээр ашигт малтмал олборлосон тохиолдолд илүү хамааралтай. Харин энэ нь тусгай зөвшөөрөлтэй эсхүл бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээтэй боловч байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, геологи, уул уурхайн ажилд хуулиар тавигдах шаардлагыг биелүүлэхгүйгээр үйл ажиллагаагаа явуулж буй аж ахуйн нэгж, бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй нөхөрлөлд хамаарахгүй юм.

Цаашилбал ТХШтХ-ийг хэрэгжүүлэх журмыг тодорхойлох зорилгоор Улсын мэргэжлийн хяналтын газар (хуучин нэрээр)-ын даргын 2008 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 163 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Захиргааны журмаар эд зүйлийг хураах, улсын орлого болгох, устгах журам баталсан боловч уг журмыг ХЗДХЯ-ны 2018 оны 1 дүгээр сарын 25-ны 1-1/493 тоот албан бичгээр захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлээс хассан байна.³⁴ Ийнхүү нэгдсэн бүртгэлээс хассанаар тухайн акт хүчин төгөлдөр бус болох ба үр дүнд нь Зөрчлийн тухай хуульд тодорхойлон зааснаас бусад зөрчлийн үед улсын байцаагчдын зүгээс аж ахуйн нэгж, иргэний хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг хураах, улсын орлого болгох арга хэмжээ авах боломжгүй болжээ.

Улсын байцаагчийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх, үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал тавих асуудлаар: ТХШтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.12.3 дахь заалтаар улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын ахлах байцаагчгүй суманд улсын байцаагч нь зөрчил арилгах тухай шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол улсын байцаагчийн шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх эсхүл тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхтэй байна. Ярилцлагын судалгааны явцад зөрчил арилгах тухай шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд шийдвэрийг шүүхээр баталгаажуулан албадан гүйцэтгүүлэх тохиолдол гардаг гэж судалгаанд оролцогч мэргэжлийн хяналтын байцаагчийн зүгээс онцолж байсан юм. Хэдий тийм боловч Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлүүдийн хувьд авсан албадан шаардлага, шийдвэрүүдийг ЗШШтХ-ийн 7.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу шүүхэд хүсэлт гарган, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээс бусад тохиолдолд хэрхэн албадан гүйцэтгүүлэх нь тодорхойгүй байна.

Тэрчлэн зөрчил арилгах тухай шаардлага биелүүлээгүй тохиолдолд ашигт малтмал олборлох, ашиглах, хайх үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлтээ холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бүрэн эрхийг ТХШтХ-д тусгасан байх боловч АМтХ-

³⁴ <https://www.legalinfo.mn/annex/details/338?lawid=1351>

ийн 56 дугаар зүйлд заасан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэлд мэргэжлийн хяналтын байгууллагаас санал хүсэлт ирсэн гэсэн заалт байхгүй тул практикт ийнхүү хүсэлт, дүгнэлт явуулсан ч үр дүнгүй байдаг байна. Үүнийг шийдвэрлэх үүднээс Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагчаас гаргаж хүргүүлсэн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал, дүгнэлтийг судлан үзэж, холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэж байхыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Цэрэнбат, Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгожээ.³⁵ Гэвч ийнхүү үүрэг болгох ажиллагаа нь ч хуульд нийцээгүй байх тул хэрэгжилт багатай байгааг онцлох нь зүйтэй юм.

– *Хариуцлагын механизм сул:*

Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл нь ТХШТХ-ийн зөрчлийг тодорхойлсон байх боловч энд зөвхөн хяналт шалгалтад хамрагдах шаардлагатай этгээд нь хяналт шалгалтаас зайлсхийсэн, дотоод хяналт шалгалтын журам тогтоож мөрдүүлээгүй болон шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан, засварласан, гэмтээсэн, зайлсхийсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн гэсэн хэдхэн зөрчлийг тусгасан нь ТХШТХ-ийн хүрээнд хяналт шалгалт явуулж буй улсын байцаагчийн шийдвэрийн биелэлтийг хангах хангалттай механизм болж чадахгүй байна. Нөгөө талаас торгуулийн дээд хэмжээ нь 1,000,000-5,000,000 төгрөг байгаа нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн хувьд хариуцлагын хангалттай механизм болж чадахгүй юм.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах зөрчлүүдийг тусгасан ч зөрчил гаргасан хуулийн этгээдийг таван зуун нэгж буюу 500,000 төгрөгөөр торгохоор тусгасан нь үр дүн муутай байна.

³⁵ <http://inspection.gov.mn/new/?p=469>

2.3.3. Хяналт шалгалтыг объектын эрсдэлийн ангилалд үндэслэн явуулах нь үр нөлөөтэй байдалд нөлөөлөх эсэх

ТХШТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангилалд үндэслэх үндсэн зарчимтай. Тус заалтыг үндэслэн Засгийн газрын 2012 оны 23 тоот тогтоолын хавсралтаар Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийг тогтоон, түүний 2.1 дэх хэсэгт байгаль орчны хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна³⁶. Уг шалгуур үзүүлэлтэд үндсэн таван асуудлын хүрээнд дүгнэлт өгч, эрсдэлийн ангилал тогтоожээ. Үүнд:

- Үйл ажиллагааны нарийн төвөгтэй шинж байдал;
- Үйл ажиллагааны явцад ялгаруулах хий, бохирдол;
- Бизнес, үйлдвэрлэлийн газрын байршил;
- Байгальд хор нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны менежмент;
- Хууль тогтоомжийг дагаж мөрдөж байгаа байдал.

Ийнхүү дээр дурдсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд эрсдэлийг тогтоон, хяналт шалгалтыг төлөвлөх нь уул уурхайн салбарын онцлогтой хэр нийцэх, цаашлаад эрсдэлийг тодорхойлох шалгуур үзүүлэлт нь хэр оновчтой байна вэ гэсэн асуулт зүй ёсоор тавигдаж байна. Эрсдэлд үндэслэсэн хяналт шалгалт нь хэдийгээр нэг талаас хариуцлагатай ажиллаж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, урамшуулах зорилготой боловч нөгөө талаас үнэхээр хариуцлагагүй ажиллаж, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж буй аж ахуйн нэгжүүдийг уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүрэн тодорхойлж чадаж буй эсэхэд дүгнэлт өгөх шаардлагатай. Иймд Засгийн газрын 2012 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлтийн 2.1 дэх хэсэг буюу байгаль орчны хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтүүдийн тодорхой заалтуудад дүн шинжилгээ хийж үзлээ.

³⁶ <https://www.legalinfo.mn/annex/details/3028?lawid=5617>

Байгаль орчны хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн 1.1-д тухайн орчинд үзүүлэх нөлөөллийг агаар, хөрс, ус зэргийг бүгдийг нь эсхүл аль нэгийг нь илүү бохирдуулах, алийг нь ч бохирдуулахгүй гэх байдлаар ангилан, тус бүрд нь нэгээс 10 хүртэлх оноогоор үнэлэхээр тусгасан. Энэ нь хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд л ялгавартай байдлаар үйлчлэхээс бус ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хувьд нэг нийтлэг хариулт буюу тухайн үйл ажиллагаа нь агаар, хөрс, ус зэргийг тодорхой байдлаар бохирдуулах эсхүл агаар-хөрс, хөрс-ус эсхүл агаар-ус бохирдуулах аюултай гэсэн хариултын аль нэг л байхаар байна. Ийнхүү эрсдэлийг дөрөв ангилж, аль нэгийг нь л илүү бохирдуулах аюултай гэсэн нь тухайн үнэлгээг хийж буй этгээдийн үзэмжээр шийдвэрлэгдэх боломжтой хариулт юм. Түүнээс гадна ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид хамаарахгүй гэж хэлж болох “алийг нь ч бохирдуулахгүй” гэх хариултыг нэмж оруулсан нь ач холбогдолгүй байна. Түүнчлэн тус шалгуур үзүүлэлтийн 2.3-2.5 дахь хэсэгт хөрс, агаар болон усны бохирдлын хэмжээ зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрдэг, хэтэрдэггүй гэсэн шалгуур үзүүлэлт тусгажээ. Зөвхөн хяналт шалгалтын явцад л тодорхойлох боломжтой асуудлыг яагаад ийнхүү эрсдэлийн ангилалд оруулсан нь ойлгомжгүй байна. Энэхүү асуудлыг тухайн аж ахуйн нэгжийн өөрсдийнх нь мэдээлсэн тоо баримтаас авдаг тухай ярилцлагад оролцсон мэргэжлийн хяналтын улсын байцаагч хэлж байсан юм. Ийнхүү тухайн аж ахуйн нэгжийн ирүүлсэн тоо, баримтыг үндэслэн зөвшөөрөгдөх хэмжээ хэтэрсэн эсэх асуудлыг тодорхойлдог нь тэдний өгсөн мэдээллийн үнэн зөв байдлаас бүхэлдээ хамаардаг учир дутагдалтай.

Шалгуур үзүүлэлтийн 3.1 дэх хэсэгт “бизнес, үйлдвэрлэлийн байршил” гэсэн үзүүлэлт оруулсан байх бөгөөд энэ нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдэд төдий л хамааралгүй, ач холбогдол багатай гэж үзэж байна. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд гурван хариулт байх бөгөөд тэдгээрийн хамгийн эхнийх нь “Хүн ам оршин суудаг төвлөрсөн болон тухайн үйл ажиллагааг хориглосон бүсэд байрладаг” гэсэн хариулт байв. Өөрөөр хэлбэл, хүн ам оршин суудаг төвлөрсөн бүс бөгөөд тус бүсэд тухайн үйл ажиллагааг хориглосон байх гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг зэрэг хангасан тохиолдолд энэхүү

хариултыг сонгож, 10 оноо өгөх бөгөөд уул уурхайн үйл ажиллагааны хувьд уг хариултыг сонгох бараг боломжгүй юм. Нөгөө талаас зөвшөөрөгдсөн үйлдвэрийн бүсэд байрладаг гэх хариулт нь уул уурхайн компаниудын хувьд хэрхэн тайлбарлах нь тодорхойгүй, үйлдвэрийн бүсэд байрлаагүй бол бусад хоёр хариултын заавал аль нэгийг сонгох байдлаар тусгасан нь учир дутагдалтай юм.

Мөн тухайн ай сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа үйлдвэрлэлийн тоо бага компанийн эрсдэлийн ангиллыг бага гэж үзэх, эсрэгээрээ нэг бүс нутагт эсхүл ойролцоо байршилд олон уул уурхайн компани ажиллаж байгаа газарт хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа боловч хариуцлагатай байдлаар байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулж, нөхөн сэргээлтээ цаг тухайд нь хийж буй компаниудын хувьд эрсдэл өндөр гарах өрөөсгөл хандлагатай байна. Түүнчлэн техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийдэг эсэх, мэргэжлийн боловсон хүчинтэй эсэх, дотоод хяналт шалгалт хийдэг эсэх зэрэг компаниас гаргаж ирүүлдэг мэдээлэл, мөн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, хөтөлбөртэй эсэх зэрэг баримт бичгийн бүрдэл хэсэгт илүү ач холбогдол өгсөн нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн хувьд байгаль орчинд учруулах эрсдэлийг бодитоор үнэлэх оновчтой шалгуур болж чадахгүй юм.

Ярилцлагын судалгаанд оролцсон мэргэжлийн хяналтын байцаагчийн зүгээс өмнө онд хийсэн шалгалтын явцад хяналтын хуудсаар хангалттай үнэлгээ аваагүй, эрсдэлтэй гэж тодорхойлсон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийг дараа жилийн төлөвлөгөөнд заавал дахин оруулж шалгалт хийдэг тухай дурдаж байсан юм. Энэ нь гүйцэтгэлийн шалгалтыг төлөвлөгөөт шалгалтын хэлбэрээр хийж байгаа явдал мөн.

Уул уурхайн салбарын онцлог нь байгаль орчинд тодорхой хэмжээний нөлөөлөл үзүүлэх нь гарцаагүй байдаг тул тухайн нөлөөллийн хэмжээг байж болох хамгийн бага түвшинд бууруулах, эвдэгдсэн, сүйдсэн орчныг анхны байдалд нь аль болох дөхүү байдлаар нөхөн сэргээх нь хамгийн чухал билээ. Гэтэл эрсдэлд үндэслэсэн хяналт шалгалтын тогтолцооны хүрээнд тухайн уул уурхайн компанийн гаргаж өгсөн мэдээлэл, баримт бичигт үндэслэсэн эсхүл тухайн үнэлгээг хийж буй албан тушаалтны үзэмжээр шийдэх, бүр зарим шалгуур үзүүлэлтийн

хувьд уул уурхайн үйл ажиллагаанд огт хамааралгүй үзүүлэлтээр эрсдэлийг тодорхойлох нь учир дутагдалтай.

Ярилцлагын судалгааны явцад эрсдэлийн ангиллыг үндэслэх энэхүү зарчим нь уул уурхайн салбарын хөгжил тодорхой түвшинд хүрсэн буюу хуулийн зөрчил бага гардаг нөхцөлд илүү тохиромжтой зохицуулалт бөгөөд харин Монгол шиг хариуцлагатай уул уурхайн хөгжлийн эхний шатанд яваа улс орны хувьд тохиромж муутай гэж зарим оролцогч онцолж байв. Ялангуяа эрсдэлийн ангиллыг оновчтой тодорхойлоогүй нөхцөлд зарим төрлийн үйл ажиллагаа хяналтаас гадуур үлдэх эрсдэлтэй.

2.3.4. Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн шалгалтын үр нөлөөтэй байдал

Хяналт шалгалтад мөрдөх нийтлэг үндэслэлийг хуульд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус болон гүйцэтгэлийн хяналт шалгалт³⁷ гэж ангилдаг. Энэхүү ангилал нь практикт, ялангуяа уул уурхайн салбарын онцлогт хэр нийцсэн болох, ямар үр нөлөөтэй байгааг судаллаа.

ТХШТХ-д зааснаар төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд ТХШТХ-ийн 5^{1.1}-д “Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагаас дараа жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдэлийн үнэлгээг харгалзан мэргэжлийн хяналтын төв байгууллага өмнөх жилийн 12 дугаар сарын 1-ний өдрийн дотор баталж, олон нийтэд мэдээлнэ” гэж заасны дагуу МХЕГ-ын дарга жил бүр дараа жилийн төлөвлөгөөг баталж, цахим хуудсаар дамжуулан нийтэд зарладаг. Ийнхүү төлөвлөгөөт хяналт шалгалтын товыг нийтэд зарлахаас гадна тухайн шалгуулагч этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх, ингэхдээ шалгалт хийх байгууллагын нэр, шалгалт эхлэх, дуусах хугацааг заахаар³⁸ хуульд заасан. Энэ нь нэг талаас төрийн хяналт шалгалтын байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчмыг хангах зорилготой боловч нөгөө талаас шалгуулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэгэнт тов нь гарсан шалгалтад зориулж

³⁷ ТХШТХ-ийн 5.1 дэх заалт.

³⁸ ТХШТХ-ийн 5^{1.2} дахь заалт.

зөрчил, дутагдлаа нуун далдлах, хяналт шалгалтыг аргалах, хяналт шалгалтаар очиж буй эрх бүхий албан тушаалтан, түүний шийдвэрт аливаа байдлаар нөлөөлөх, дарамт үзүүлэх зэрэг хяналт шалгалтын үр нөлөөг бууруулах зорилготой үйл ажиллагаа явуулах тохиолдол цөөнгүй гарч байна.³⁹

Мөн төлөвлөгөөт хяналт шалгалт хийхэд “Хяналт шалгалтыг төлөвлөхдөө тухайн объектын эрсдэлийн ангиллыг үндэслэх” болон “Хяналт шалгалтыг давхардуулахгүй байх” зарчмуудыг удирдлага болгож байгаа ч мэргэжлийн хяналтын байгууллагаас бусад эрх бүхий хяналтын байгууллагын хяналт шалгалттай цаг хугацаа, агуулга, хяналтын зүйлийн хувьд давхардах асуудал гардаг байна. Энэ нь хяналт шалгалтын үр нөлөөг бууруулах, шалгуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд дарамт, чирэгдэл үүсгэх шалтгаан болж байна. Мөн эрсдэлийн ангиллыг үндэслэх зарчмыг өмнө хийсэн шалгалтын хүрээнд зөрчилтэй гарсан аж ахуйн нэгжүүдийг хамруулах байдлаар хэрэгжүүлэх, эрсдэлийн ангиллыг тогтоох шалгуур үзүүлэлтүүдэд үнэлгээ өгч буй этгээдийн хувийн үзэмжээс хамаарсан эсхүл тухайн уул уурхайн компанийн зүгээс гаргаж өгч буй мэдээ, мэдээлэлд үндэслэсэн байдлаар хэрэгжүүлж буй нь хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын төлөвлөгөөтөөс ялгагдах онцлог нь зөвхөн хууль, тогтоомжид заасан үндэслэлээр буюу иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр эсхүл осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд болон шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд хийгддэг. Гэхдээ ТХШТХ-ийн 5².2 дахь хэсэгт иргэн, хуулийн этгээд өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийг зохих нотлох баримтын хамт ирүүлсэн байхыг шаарддаг бөгөөд зөвхөн мэргэжлийн хяналт шалгалтын байгууллагын зүгээс уг мэдээлэл, гомдол, өргөдөл, хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл хяналт шалгалт хийхээр зохицуулжээ. Энд заасан “үндэслэлтэй” гэх ойлголт нь хууль зүйн үүднээс тайлбарлахад төвөгтэй, тодорхойгүй учир зөвхөн мэргэжлийн хяналтын байгууллага, байцаагчийн үзэмжээр шийдэгдэх боломжтой байна.

³⁹ Ийм тохиолдол практикт нэлээд гарч байгаа талаар хяналт шалгалтын эрх хэрэгжүүлэгч албан тушаалтнууд ярилцлагын үеэр дурдаж байв.

Мөн иргэд уул уурхайтай холбоотой асуудлыг УУХҮЯ эсхүл БОАЖЯ, АМГТГ шийдвэрлэх, хяналт тавих ёстой гэж ойлгодог учир эдгээр байгууллагад хаяглагдсан гомдол, мэдээлэл их ирдэг байна. Энэ тохиолдолд тухайн зөрчлийн шинж чанарыг харгалзан холбогдох төрийн байгууллагууд болон мэргэжлийн хяналтын байгууллагын төлөөллийг оролцуулсан ажлын хэсэг байгуулан, зарим тохиолдолд аль нэг сайдын баталсан удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийдэг практик их байна. Гэхдээ хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллах эсхүл тухайн гомдол, мэдээлэл, өргөдлийг мэргэжлийн хяналтын байгууллагад шилжүүлэх асуудлыг зөвхөн тухайн гомдлыг хүлээн авсан төрийн байгууллага үзэмжээрээ шийдэж байгааг энд тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, Эко Алтан Заамар, Монгол Газар зэрэг компанид холбогдох олон нийтийн анхаарлыг татсан томоохон осол аваар, хохирлын тохиолдолд дээрх байдлаар төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж байжээ.

Гүйцэтгэлийн хяналт шалгалт нь өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар өгсөн шаардлагын биелэлтийг хянах зорилгоор хийгддэг.⁴⁰ Иймд хяналт шалгалтын үр нөлөөг үнэлэхэд ач холбогдлын хувьд хамгийн чухал боловч өнөөгийн практикаас харахад дараа жилийн төлөвлөгөөт шалгалтаа хийхдээ өмнө зөрчил гаргасан аж ахуйн нэгжид гүйцэтгэлийн шалгалт хийх зэргээр ажиллах тохиолдол байгааг судалгаанд оролцогчид хэлж байсан юм. Энэ нь мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэлийн шалгалтыг бүтэн жилийн дараа буюу хугацаа хожимдуулан хийх, гаргасан зөрчил, дутагдлыг цаг тухайд нь арилгаж буй эсэхэд хяналт тавьж чадахгүй байгааг илэрхийлж байна.

Мөн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалттай холбоотой анхаарал татсан өөр нэг асуудал нь ТХШТХ-ийн 5^{1.2} дахь хэсэгт заасан хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөт шалгалт хийх тухайгаа шалгуулах этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө мэдэгдэх, ТХШТХ-ийн 5^{3.3}-т зааснаар гүйцэтгэлийн шалгалтын үед ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэх ёстой гэсэн шаардлага юм. Мэргэжлийн хяналтын байгууллагын зүгээс төлөвлөгөөт шалгалтын үед, тухайлбал, хуульд заасан тав хоногийн өмнө мэдэгдэх үүргийнхээ дагуу тухайн аж ахуйн нэгжид мэдэгдмэгц аж ахуйн нэгж,

⁴⁰ ТХШТХ-ийн 5^{3.1} дэх заалт.

бичил уурхай эрхлэгчдийн зүгээс хууль бусаар явуулж байсан үйл ажиллагаагаа нуун дарагдуулах, оргон зайлах, уурхайгаа түр хаагаад алга болох зэргээр хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад болох, хүндрэл учруулж, шалгалтын үр нөлөөг бууруулах явдал цөөнгүй гардаг талаар ярилцлагад оролцогчид дурдаж байв. Уурхайгаа хаагаад алга болсон эсхүл улсын байцаагчийн дуудсан цагт хүрэлцэн ирэхгүй байгаа тохиолдолд албадан ирүүлэх арга хэмжээг зөвхөн цагдаагийн байгууллага л авах боломжтой тул цагдаагийн эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээж цаг алдах явдал гардаг. Энэ нь хяналт шалгалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлж чадахгүйд хүрдэг талаар мөн ярьж байсан болно.

2.3.5. Хяналтын хуудас нь хяналт шалгалтын үр нөлөөтэй байдалд нөлөөлөх эсэх

Уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналт шалгалтын тогтолцоонд төрийн хэд хэдэн байгууллага оролцдог. Байгаль орчин, хариуцлагатай уул уурхайн асуудлаарх судалгаанаас харахад Монгол Улсад уул уурхайн үйл ажиллагаа эрхлэхэд тусгай зөвшөөрөл авч, хуульд заасан шаардлагын дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулдаг ч тэдгээр нь үнэн зөв, бодитой хийгдсэн эсэх, эргээд хэрэгжих боломжтой эсэхийг хянан шалгах, дүгнэх оновчтой тогтолцоо бүрэн бүрдээгүй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталдаг хэр нь хяналт хэрэгжүүлэгч мэргэжлийн хяналтын байгууллагатай эргээд хэр уялдаатай ажиллах талаар зохицуулалт байхгүй, зөвхөн байгууллага хооронд тогтсон практикт тулгуурлан ажиллаж байна. Энэ нь аж ахуйн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх, бохирдол, доройтол бий болоход ямар нэг хэмжээгээр нөлөөлдөг.

Хяналт шалгалтын байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг үнэлэхийн тулд эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт хийхэд ашиглаж буй удирдамж, хяналтын хуудас зэрэг үндсэн баримт бичгүүд нь агуулгын хувьд хэр оновчтой эсэхэд дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлагатай.

Мэргэжлийн хяналтын байгууллага нь 2011 оноос МХЕГ-ын даргын тушаалаар баталсан хяналтын хуудас ашиглаж байна. Хяналтын хуудас нь хяналт шалгалтын байгууллага, улсын байцаагчийн үйл ажиллагааг нээлттэй, ил тод байлгах зорилготой.⁴¹ Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарын байгаль орчны хяналт шалгалтад МХЕГ-ын даргын баталсан “Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-ыг үндсэн эх сурвалж болгон ашигладаг бөгөөд үүнд ил уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, далд уурхайн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас, баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас тус тус багтаж байна.

Тус хяналтын хуудсанд хяналт шалгалтын объект тус бүрээр байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй эсэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй эсэх болон газар ашиглалт, хөрсний бохирдол, бохир ус, агаарын бохирдол, ус ашиглалт, газрын хэвлийн ашиглалт болон нөхөн сэргээлт зэргийг хянахаар оруулсан нь “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах, судлах аргачлал”-ын байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг дүгнэх үзүүлэлттэй бүрэн дүйцсэн, зарим талаар илүү дэлгэрэнгүй байна. Ийнхүү хэдийгээр хяналтын хуудсанд хяналт шалгалтын зүйлсийг бүрэн тусгасан ч үүний дагуу хийгдсэн шалгалтын үр нөлөө бодит байдалд ямар байгааг доорх хүснэгтэд үзүүллээ.

⁴¹ http://inspection.gov.mn/new/?page_id=23

Хүснэгт 3. Хяналтын хуудсанд хийсэн дүн шинжилгээ

Хяналт шалгалтын зүйл	Хяналт шалгалтын зүйлийг шалгах эрх зүйн үндэслэл, зохицуулалт	Хяналт шалгалтын нөлөөтэй байдал
Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй эсэх	БОНБҮТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ гэдэгт стратегийн үнэлгээ, төлөв байдлын үнэлгээ, нөлөөллийн үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ тус тус багтдаг. ⁴² Гэвч уул уурхайн компаниуд нь эдгээрээс төлөв байдлын үнэлгээг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хамт хийлгүүлсэн байх ёстой.	АМТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.1.7-д заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөлд заавал хавсаргах баримт бичгийн нэг. Гэхдээ байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсэх өргөдлийн нэг гол бүрдэл юм. Учир нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр явагдах үйл ажиллагаанаас байгаль орчинд учирч болох нөлөөллийг бодитойгоор, тоо баримтаар тодорхойлох зорилготой. Гэтэл хяналтын хуудсаар зөвхөн төрийн захиргааны төв байгууллагаар үнэлгээ батлуулсан эсэхийг л шалгахаас бус тухайн үнэлгээ нь агуулгын хувьд бодитой эсэх, гаргасан тоо баримт нь үнэн зөв эсэхийг тодруулан шалгах боломжгүй байна.

⁴² БОНБҮТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3 дахь хэсэг.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй эсэх	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын баталсан А-05 тоот журмын дагуу төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хүлээн авч шалгана. Ийнхүү шалгахад аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, 12 дугаар сарын 1-ний дотор дүгнэлт гаргуулна. Уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.	Хяналтын хуудсанд: <ul style="list-style-type: none"> - Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх; - Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх; - Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх; - Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх; - Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх; - Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу арга хэмжээ авсан эсэх зэргийг тус тус шалгахаар тусгасан. Энэ нь хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгжүүд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг жил бүр батлуулж, хэрэгжүүлэхийн учир
---	---	--

Хүснэгт 3-ын үргэлжлэл

		шалтгааныг ойлгож, төлөвлөгөөгөө бодитой, үнэн зөв гарган батлуулахад ач холбогдолтой.
Байгаль орчны аудитыг хоёр жил тутамд хийлгэсэн эсэх ⁴³	Байгаль орчны аудитын үйл ажиллагааг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/809 дүгээр тушаалаар баталсан “Байгаль орчны аудит хийх эрх олгох журам”-аар зохицуулдаг. Тус журмын 1.2-т “Байгаль орчны аудит хийх эрхийг холбогдох хууль, энэ журамд заасан шаардлага, нөхцөлийг хангасан Монгол Улсын хуулийн этгээдэд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгоно” гэж заасны дагуу олгодог.	Хяналтын хуудсанд зааснаар байгаль орчны аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу сөрөг нөлөөллийг бууруулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн эсэхийг нь хянан шалгах эрх бүхий этгээд нь мэргэжлийн хяналтын байгууллага байна. Гэтэл аудитаас өгсөн зөвлөмжийн талаар мэргэжлийн хяналтын байгууллага хэрхэн олж мэдэх, аудитын байгууллага энэ талаар ямар үүрэг хүлээх нь тодорхойгүй байна. Түүнээс гадна байгаль орчны аудитыг хуульд заасны дагуу хоёр жил тутамд хийлгэсэн эсэхийг эрх зүйн ямар баримт бичгийг үндэслэн шалгах нь тодорхойгүй байна. Байгаль орчны аудит хийх эрх олгох журмын 4.2.1-т “Байгаль орчны аудитын үйл ажиллагааны явцад захиалагч нь байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчил гаргасан, гаргах нөхцөл

⁴³ БОНБУТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

		байдал үүсгэсэн бол зохих байгууллагад мэдэгдэх” гэж заасан. Зохих байгууллага гэж ямар байгууллагыг ойлгох нь тодорхойгүй буюу хяналтын хуудсанд заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага гэж шууд ойлгож болох эсэх нь эргэлзээтэй байна.
--	--	---

Газар ашиглалт	Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2-т “Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг хууль тогтоомжийн дагуу эрх олгогдсон байгаль орчны хяналтын газар болон ургамал, хорио цээр, эрүүл ахуй, геологи, уул уурхайн зэрэг мэргэжлийн байгууллагууд хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага нь газар ашиглалтад хамаарах хяналтыг хэрэгжүүлнэ.	Мэргэжлийн хяналтын байгууллага уул уурхайн газар ашиглалттай холбоотой хяналт хэрэгжүүлэх эрхтэй ч зөвхөн газрын төлөв байдал, чанарын хянан магадалгаатай эсэхийг л шалгахаас бус, тэрхүү хянан магадалгааны техникийн нарийвчилсан үзүүлэлтүүд, түүний хэрэгжилтийг шалгадаггүй.
----------------	--	---

Хөрсний бохирдол	БОХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.6 болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын баталсан А-05 тоот журмын дагуу төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хүлээн авч шалгана. Ийнхүү шалгахад аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, 12 дугаар сарын 1-ний дотор дүгнэлт гаргана. Уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.	Хөрсний болон усны бохирдлыг тогтоохын тулд хяналтын хуудсанд заасны дагуу хөрсний, хүнд металлын, хөрсний нянгийн болон химийн бохирдлын шинжилгээ, түүнчлэн усны шинжилгээ, түүний дотор бохир устай холбоотой нарийвчилсан олон шинжилгээ хийх шаардлагатай. Гэтэл практикаас харахад Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын харьяа төвлөрсөн ганц лабораторид л улсын хэмжээнд ус, хөрсний шинжилгээ хийж байгаагаас өргөн уудам газар нутгийн өнцөг булан бүрд явагдаж буй уурхайн үйл ажиллагаанаас газрын хөрс, усанд учруулж буй аливаа сөрөг нөлөөлөл, бохирдлыг тухай бүр бодитойгоор тогтоох боломжгүй.
---------------------	--	---

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Агаарын бохирдол	<p>БОХТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.7, Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг болон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын баталсан А-05 тоот журмын дагуу төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг аймаг, нийслэлийн Байгаль орчны газар хүлээн авч шалгана. Ийнхүү шалгахад аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж, 12 дугаар сарын 1-ний дотор дүгнэлт гаргана. Уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.</p>	<p>Орчны агаарын шинжилгээ болон агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч буй (усалгаа, боловсруулсан түлш, цахилгаан ашигладаг, утаа шүүх тоног төхөөрөмж суурилуулсан гэх мэт) эсэхийг тогтоох нь агаарын бохирдолтой холбоотой хяналтын гол зүйл юм. Эдгээрийг бодитой тогтооход дээр дурдсантай адил агаарын чанарт шинжилгээ хийх шаардлагатай. Гэсэн ч нарийвчилсан стандартад заасан хэмжигдэхүүнүүдийг тодорхойлох багаж хэрэгсэл байхгүй, тухайн асуудлаарх байцаагчдын мэдлэг хангалтгүй байгаагаас агаарт үзүүлж буй сөрөг нөлөөллийг цаг тухайд нь бодитойгоор тодорхойлох боломж хязгаарлагдмал байна.</p>
---------------------	---	--

Ус ашиглалт	<p>Усны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.1, 28.4, 28.11, 30 дугаар зүйлийн 30.14 болон 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн дагуу мэргэжлийн хяналтын газар, мөн Усны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан эрх бүхий этгээдүүд хариуцсан нутаг дэвсгэртээ усны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авах эрхтэй.</p>	<p>Хяналтын хуудасны ус ашиглалттай холбоотой хяналтын зүйлийг харахад мэргэжлийн хяналтын байгууллагаас шалгалт хийхдээ зөвхөн тухайн аж ахуйн нэгж ус ашиглахтай холбоотой бичиг баримтын бүрдлийг хангасан эсэх, холбогдох дүгнэлт, зөвшөөрөл авсан эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэхийг л шалгахаас бус хэдий хэмжээний ус ашиглах, тэр хэмжээгээ хэтрүүлсэн эсэх, ус ашигласнаар байгаль орчинд ямар нэг сөрөг нөлөө үүссэн эсэхийг хянах боломжгүй байна.</p>
Нөхөн сэргээлт	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/419 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр баталсан 120 тоот журам, БОХтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.5 дахь хэсгийг удирдлага болгон Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын</p>	<p>Хяналт шалгалтын зүйлийг харахад нөхөн сэргээлт хийсэн тухай улсын байцаагч дүгнэлт гаргасан эсэхийг л шалгахаас бус, дүгнэлтийн агуулга, үнэн зөв эсэхийг газар дээр нь шалгадаггүй байна.</p>

Хүснэгт 3-ын үргэлжлэл

шийдвэрээр улсын
байцаагч, байгаль
хамгаалагч нөхөн
сэргээлтийн үйл
ажиллагаанд хяналт
тавина. Өөрөөр
хэлбэл, нөхөн
сэргээлтийн асуудлаар
дээр дурдсан бүх
этгээд аж ахуйн
нэгжид шаардлага
хүргүүлэх, хяналт
тавих эрхтэй.

Газрын
хэвлий
ашиглалт

Газрын хэвлийн
тухай хуулийн 6
дугаар зүйлийн
6.3.3-т “Геологи, уул
уурхайн асуудал
эрхэлсэн төрийн
захиргааны төв
байгууллага газрын
хэвлийг ашиглах,
геологийн судалгаа
хийх үйл ажиллагаанд
төрийн хяналтыг
хэрэгжүүлэх”, мөн
зүйлийн 6.4.1-д
“Байгаль орчны
асуудал эрхэлсэн
төрийн захиргааны
төв байгууллага
нь газрын
хэвлийг ашиглах,
хамгаалах талаарх
төрийн бодлогыг
хэрэгжүүлэх, газрын
хэвлийг ашиглах үйл
ажиллагааг байгаль
орчинд сөрөг

Газрын хэвлийн ашиглалттай
холбоотой хяналтын зүйл
нь харьцангуй бодитой,
дэлгэрэнгүй тусгагдсан
байна. Тухайлбал, тусгай
хамгаалалттай газар,
байгалийн болон түүх,
соёлын дурсгалт зүйлийн
хадгалалт, хамгаалалтыг
хангах, цаашид тухайн
газрын хэвлийг ашиглахад
аюул осол сөрөг
нөлөөлөлгүйгээр нөхөн
сэргээсэн эсэхийг шалгадаг.

нөлөө багатайгаар
хэрэгжүүлэхэд төрийн
хяналт тавих” эрхтэй
гэж заажээ. Үүний
дагуу УУХҮЯ болон
БОАЖЯ аль аль нь
уул уурхайд газрын
хэвлийг ашиглахтай
холбоотой үйл
ажиллагаанд төрийн
хяналт хэрэгжүүлдэг.

Хүснэгт 3-т дурдсан хяналтын хуудасны агуулгад дүн шинжилгээ хийхэд ихэнх хяналтын зүйл нь байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг бодитой тодорхойлох боломжгүй эсхүл орон нутагт шаардлагатай багаж, тоног төхөөрөмж дутагдалтай байдгийн улмаас зөрчлийг газар дээр нь шуурхай, бодитой тогтоох боломжгүй нь харагдаж байна. Энэ нь хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

Түүнчлэн хяналтын хуудасны агуулга оновчтой бус, тухайн аж ахуйн нэгж шаардлагатай баримт бичгийн бүрдэл хангасан эсэхийг түлхүү шалгахаас бус, бүрдүүлбэрт байгаа бичиг баримтын үнэн зөв байдал, хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянах, шалгах боломжгүй байна. Учир нь холбогдох төрийн байгууллагуудын зүгээс хийж буй хяналт шалгалтын үеэр аж ахуйн нэгжүүд хяналтын хуудсанд тусгасан баримт бичгүүдийн зөвхөн эхний нэг, хоёр нүүрийг хэвлэн уурхай дээрээ байлгадаг бөгөөд тэдгээрийг үзүүлэх замаар шалгалтыг аргалдаг явдал их байдаг хэмээн судалгааны явцад өгүүлсэн болно. Нөгөө талаас БОАЖЯ болон АМГТГ-ын зүгээс байгаль орчны үнэлгээ, орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэл зэргийн чанар, үнэн зөв байдлыг бүрэн хяналгүй баталдаг нь хүндрэл учруулдаг байна.

Үүнээс гадна хяналтын хуудас боловсруулахад удирдлага болгосон Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын А-05 тоот тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019

оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалаар хүчингүй болгож, шинэчлэн баталсан байна. Гэтэл энэхүү судалгааг гүйцэтгэх цаг хугацаанд буюу 2020 оны 8 дугаар сарын байдлаар шинээр батлагдсан журмын дагуу хяналтын хуудсанд холбогдох нэмэлт өөрчлөлт ороогүй, хүчингүй болсон журмыг удирдлага болгосон хэвээр байв.

2.3.6. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдон үүсэж буй хүндрэлтэй асуудал хяналт шалгалтын үр нөлөөтэй байдалд нөлөөлөх нь

Өнөөдрийн байдлаар АМГТГ-аас олгосон ашигт малтмалын хайгуулын нийт 987 тусгай зөвшөөрөл, ашигт малтмалын ашиглалтын 1,675 тусгай зөвшөөрөл байна.⁴³ Эдгээрээс жил бүр хамгийн багадаа 300 орчим нь ашиглалтын болон олборлолтын үйл ажиллагаа явуулж, уулын ажлын төлөвлөгөөг АМГТГ-т өгдөг байна.⁴⁴ Гэтэл МХЕГ-ын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газарт дөнгөж дөрвөн ахлах байцаагч, хоёр улсын байцаагч ажиллаж байгаа бол уул уурхайн үйл ажиллагаа төвлөрсөн Дорноговь аймагт гурав⁴⁵, Дорнод аймагт гурав,⁴⁶ Сэлэнгэ аймагт хоёр, бусад аймагт нэг нэг байгаль орчны хяналтын улсын байцаагч тус тус ажиллаж байна. Энэ нь байгаль орчны хяналтын улсын байцаагчдын ачаалал их, үүнээс улбаалан үйл ажиллагааны хүртээмж хангалтгүй байгаагаас хяналтын ажлын үр нөлөө буурахад нөлөөлж байна.

Орон нутагт ажиллаж байгаа цөөн тооны байцаагчдын хувьд ирсэн гомдол, мэдээлэлд хуулийн хугацаанд хариу өгөх, дээд шатны байгууллагуудад тайлан, мэдээ илгээх, Шилэн дансны цахим хуудсанд

⁴³ АМГТГ-ын статистик мэдээ.
<https://www.mrpm.gov.mn/article/55/>. 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр нэвтэрсэн.

⁴⁴ АМГТГ-ын Уул уурхайн мэдээ, 2016.
<https://www.mrpm.gov.mn/article/50/>. 2020 оны 7 дугаар сарын 31-ний өдөр нэвтэрсэн.

⁴⁵ Дорноговь аймгийн Мэргэжлийн хяналтын газар.
<https://www.dornogovi.gov.mn/home/org/MHG>

⁴⁶ Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газар.
http://inspection.gov.mn/do/index.php?option=com_content&view=article&id=35&Itemid=147

акт, дүгнэлтээ ахин шивэх зэргээр бичиг цаасны маш их ажилтай байдаг тухай ярилцлагын үеэр хэлсэн юм. Байгууллагын дотоод бичиг цаасны ажил их байдаг нь хяналт шалгалт хийх цагийг хязгаарлан, хүндрэл учруулдаг байна.

Анкетын судалгаагаар мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн мэргэжил, ур чадварын талаарх асуултад судалгаанд оролцогчид харилцан адилгүй хариулт өгчээ. Ерөнхийдөө аль шатанд ажиллаж байгаагаасаа хамааран байцаагчдын мэдлэг, ур чадвар харилцан адилгүй байдлаар дүгнэгдсэн бөгөөд тухайлбал, МХЕГ-ын байцаагчдын ур чадварыг маш сайн гэсэн бол орон нутгийн байцаагчдын ур чадвар хангалтгүй, туршлагагүй гэж үнэлжээ.

Сумын байгаль хамгаалагч, сумын байгаль орчны улсын байцаагчийн мэргэжил, ур чадвар, хараат бус байдлыг судалгаанд оролцогчдын дийлэнх нь хангалтгүй гэж үнэлсэн бөгөөд хараат бус байдлын хувьд ихэвчлэн тэдгээрийг томилдог сумын Засаг даргаас хараат байдлаар ажилладаг гэж үзжээ.

*Уул уурхайн компаниудаас авсан
анкетын судалгааны үр дүнгээс*

Нөгөө талаас техник, багаж төхөөрөмж, хамгаалах хувцас, хэрэгсэл хүрэлцээ муутай байдаг тухай судалгаанд оролцсон бүх мэргэжлийн хяналтын байцаагч хэлж байсан юм. Хэдийгээр ТХШТХ-иар мэргэжлийн хяналтын улсын байцаагч нь чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай хөдөлмөр хамгааллын хувцас болон техник хэрэгслээр хангагдах баталгааг тодорхойлж өгсөн боловч төсвийн хангалтгүй байдлаас GPS, агаар, хөрс, усны бохирдлыг газар дээр нь шинжлэх багаж хэрэгсэл, унаа тэрэг хүрэлцээгүй байдаг байна. Энэ нь хяналт шалгалтыг түргэн шуурхай, үр дүнтэй хийхэд хүндрэл учруулдаг аж.

Мөн байцаагчийн аюулгүй байдлын асуудлыг ярилцлагад оролцогчид онцолсон юм. ТХШТХ-иар улсын байцаагчийн бүрэн эрхээ хэрэгжүүлж буйтай нь холбогдуулан доромжилсон, гүтгэсэн, дарамталсан, амь нас, эрүүл мэндэд нь бодит аюул заналхийлсэн бол цагдаагийн байгууллагаар аюулгүй байдлаа хангуулах арга хэмжээ авхуулах эрхтэй

гэж заасан ч практикт зөвхөн энд дурдсан үйлдлүүд хийгдсэний дараа л цагдаад хандах боломжтой байдаг. Ийнхүү бодит байдалд аюулгүй байдлаа хангуулж чадахгүй учир зарим эрсдэлтэй нөхцөлд хяналт шалгалт явуулж, зөрчил илрүүлэх боломжгүйд хүрдэг. Хууль бус ашигт малтмал олборлогчид өмнө нь орон нутгийн хүчний байгууллагад ажиллаж байсан, ял шийтгэгдэж байсан хүмүүс байх нь элбэг бөгөөд мэргэжлийн хяналтын байцаагчдыг хэл амаар доромжлох, биед нь халдах тохиолдол цөөнгүй гардаг. Хүн ам цөөн, бие биеэ харьцангуй сайн таньдаг орон нутагт ажилладаг байцаагчид гэр бүлийнхээ аюулгүй байдалд байнга санаа зовж байдаг тухайгаа ярьж байсан юм. Ийнхүү төрөөс үзүүлж буй баталгаа нь хангалтгүй байдагтай холбоотойгоор хяналт шалгалт хийхээсээ айх, эмээх, зөрчил илрүүлэх, арга хэмжээ авахаас татгалзах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй юм.

Уул уурхайн компаниуд дотоод хяналтаа хийдэггүй эсхүл дутуу хийдэг нь байгаль орчны зөрчил, осол аваарын эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах боломжийг хязгаарладаг байна.

Эцэст нь мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой заавал дурдах асуудлын нэг бол хяналт шалгалтын үеэр дээж сорьц авах, түүнийг лабораторид шинжлүүлэх асуудал юм. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хуулийн холбогдох заалтын дагуу “Нийтийн ашиг сонирхол, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, улс орны аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй бүтээгдэхүүний сорилтын лаборатори нь заавал итгэмжлэгдсэн байна”. Үүний дагуу уул уурхайн хяналт шалгалт хийж байгаа мэргэжлийн хяналтын улсын байцаагч хяналтын хуудсанд тусгагдсан байгаль орчин, хүрээлэн буй орчны зарим үзүүлэлт, тэр дундаа газрын хэвлий, хөрс, ус, агаарын дээжийг заавал итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлэх шаардлагатай болдог.

Шалгалтын үеэр стандартад нийцээгүй эсхүл хуульд заасан стандартаас хэтэрсэн хэмжээний бохирдол, хор хохирол учирч байна гэж үзвэл газар дээр нь шалгах багаж техникийн боломж байхгүйгээс гадна хуулиар шинжилгээг улсын байцаагчаас өөр гуравдагч этгээд хийх ёстой тул дээжийг заавал итгэмжлэгдсэн лабораторид илгээх, хариу гартал хүлээх хэрэгтэй болдог.

Ийнхүү дээж авах, сорьцыг шинжилгээнд өгөх, шинжилгээний хариу хүлээх зэрэг хугацаа шаардсан процессын улмаас улсын байцаагч хяналтын хуудсанд заасан зарим зүйлийг шалгахгүй орхих, шалгуулагчаас гаргаж өгсөн баримтад үндэслэн шийдвэр гаргах тохиолдол гардгийг үгүйсгэхгүй. Энэ нь төрийн хяналт шалгалтын үр нөлөөг бууруулах нэг шалтгаан болж байна. Иймээс орон нутагт хяналт шалгалт хэрэгжүүлж байгаа улсын байцаагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, хяналт шалгалтын үр дүнг сайжруулахын тулд аймаг бүрд явуулын итгэмжлэгдсэн лаборатори байгуулах шаардлага байна.

Ийнхүү мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдон үүсэж буй хүндрэлтэй асуудал болох хүний нөөц, чадавх, шаардлагатай зарим техник хэрэгсэл дутмаг байдал, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу хүлээх зэрэг нь хяналт шалгалтын үр нөлөөтэй байдалд шууд болон шууд бус нөлөө үзүүлдэг байна.

ГУРАВ. ОЛОН УЛСЫН ТУРШЛАГА

3.1. АВСТРАЛИ УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

Энэхүү судалгааны хүрээнд Австрали Улсын уул уурхайн үйл ажиллагаа хамгийн их төвлөрсөн Баруун Австрали мужийн хяналт шалгалтын тогтолцоо, зохицуулалтыг авч үзлээ.

Баруун Австрали мужид уул уурхайн үйл ажиллагааг зохицуулдаг дараах гол хуулиуд байдаг. Үүнд:

- Уул уурхайн акт (1978) болон Уул уурхайн журмууд (1981);
- Байгаль орчныг хамгаалах акт (1986);
- Байгаль орчныг хамгаалах журмууд (2005);
- Уурхайн аюулгүй байдал ба хяналтын акт (1984) болно.

Уурхайн аюулгүй байдал ба хяналтын актаар уурхайн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хяналт шалгалтын үйл явцыг зохицуулдаг бол Байгаль орчныг хамгаалах акт (1986)-аар бохирдол, хог хаягдал, дуу чимээ болон хөрс хуулалт зэрэгтэй холбоотой тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, аж ахуйн нэгжийн үүргийн хэрэгжилтийг хянах асуудлыг зохицуулдаг. Хяналт хэрэгжүүлэх гол байгууллага нь Байгаль орчны зохицуулалтын газар (*Department of Environment Regulation*) байдаг. Гэхдээ уул уурхай, газрын тосны салбар дахь байгаль орчны хяналт шалгалтыг Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт болон аюулгүй байдлын газар (*Department of Mines, Industry Regulation and Safety*) хариуцдаг. Хяналт шалгалтын үндсэн зорилго нь байгаль орчин болон иргэдийн эрүүл мэндэд “зөвшөөрөгдөхгүй хэмжээнд” эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

Хяналт шалгалтын дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Олон нийтийн эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд хамгийн их эрсдэл учруулахуйц үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжид нэн түрүүнд шалгалт хийх;
- Тухайн зөрчлийн шинж чанар, хариуцагч талын нөхцөл байдлыг харгалзан хариуцлагын арга хэмжээг тодорхойлох. Өөрөөр хэлбэл, зөрчлийн үед авах арга хэмжээ нь тухайн зөрчлийн олон нийтийн аюулгүй байдал, хүрээлэн буй орчинд үзүүлэх эрсдэл, сөрөг нөлөөллийн хэмжээ, шинж чанарт дүйцсэн байх ёстой.

Тэрчлэн хяналт шалгалтыг Монгол Улстай ижил эрсдэлийн ангилалд үндэслэн явуулдаг бөгөөд “өндөр” эрсдэлтэй гэж үнэлэгдсэн бүх аж ахуйн нэгжид тухайн жилд зайлшгүй шалгалт хийх, “дунд” эрсдэлтэй аж ахуйн нэгжүүдийн 33 хувь, “бага” эрсдэлтэй аж ахуйн нэгжүүдийн 20 хувийг тухайн жилд шалгалтад хамруулдаг.⁴⁷

Баруун Австрали мужийн хувьд байгаль орчны хууль тогтоомжоо шинэчлэх ажил одоо ид өрнөж байгаа бөгөөд байгаль орчны хяналт, тэр дундаа эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах үүднээс Эрсдэлийн үнэлгээний аргачлалын төсөл боловсруулан Байгаль орчны журмын газрын вэбсайтаар дамжуулан олон нийтээс санал авч байна. Уг аргачлалын дагуу эрсдэлийн түвшнийг тухайн компанийн үйл ажиллагааны түүх, зөрчил гаргаж байсан эсэх, өмнө хийгдсэн хяналт шалгалтын мэдээлэл, шинжээчийн дүгнэлт, судалгаа шинжилгээний бүтээл, ижил төстэй уурхайн туршлага, эрсдэлийн үнэлгээ, математикийн загварчлал зэргийг үндэслэн тогтоохоор байна.⁴⁸

Уул уурхай, аж үйлдвэрийн зохицуулалт болон аюулгүй байдлын газраас уул уурхайн компаниудын байгаль орчны үүргийн хэрэгжилтийг хянахдаа пирамидын арга хэрэглэдэг байна. Пирамидын

⁴⁷ Department of Environment Regulation, DER Annual Review and Compliance Program: 2016-17 priorities and targets.
https://www.der.wa.gov.au/images/documents/our-work/compliance/2016-17_Annual_Compliance_Program.pdf

⁴⁸ Department of Environment Regulation. Guidance Statement: Risk Assessments (February 2017).
https://www.der.wa.gov.au/images/documents/our-work/licences-and-works-approvals/GS_Risk_Assessments.pdf

суурь нь хууль тогтоомжийг сурталчлах, биелүүлж ажиллахыг уриалах буюу мэдээлэл, заавар, зөвлөгөө өгөх явдал байдаг бол дунд хэсэг нь үйл ажиллагаандаа өөрчлөлт хийхийг зөвлөх, зааварлах, сануулах, зөрчлийг арилгах арга хэмжээ авах зэрэг байдаг. Харин пирамидын орой нь хариуцлага тооцох буюу олборлолт, бусад үйл ажиллагааг зогсоох, прокурорын зүгээс зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, тусгай зөвшөөрөл, байгаль орчны төлөвлөгөөг нь цуцлах зэрэг шийтгэл оногдуулах хэсэг байдаг.⁴⁹

Шийтгэлийн төрөл, хэмжээг тодорхойлохдоо байгаль орчинд учруулсан хохирлын шинж байдал, хэмжээ, хохирлыг арилгах, байгаль орчныг нөхөн сэргээх боломж, тухайн зөрчил зөвхөн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн хүрээнд гарсан эсхүл түүнээс давсан эсэх, тухайн этгээдийн өмнө нь гаргасан зөрчлийн байдал, зөрчлийг сайн дураараа мэдэгдсэн болон цаг тухайд нь арга хэмжээ авсан эсэхийг харгалзан үздэг байна.

3.2. КАНАД УЛСЫН УУЛ УУРХАЙН САЛБАР ДАХЬ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

Энэхүү судалгааны хүрээнд Канад Улсын Алберта мужийн уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналт шалгалтын зохицуулалтыг сонгон авч судаллаа.

Алберта мужид үйлчлэх 2000 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах, сайжруулах акт нь уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх гол үүргийг хуульчилж, хяналт шалгалт хийх эрх зүйн үндэслэлийг тогтоосон гол баримт бичиг юм. Мөн Байгаль орчныг хамгаалах, сайжруулах актын зургаадугаар бүлэг нь бүхэлдээ байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудалд хамаарах бөгөөд тус актын 135 дахь хэсэгт оператор компани нь тухайн газар дээр үйл ажиллагаа явуулахтай холбоотой санхүүгийн болон бусад баталгааг гарган, даатгалд хамрагдах, байгаль орчныг хамгаалж, нөхөн сэргээх талаар тусгасан байдаг. Тус зүйлд

⁴⁹ Department of Mines, Industry Regulation and Safety, Guidance Note on Environmental Non-compliance and Incident Reporting.
<https://www.dmp.wa.gov.au/Documents/Environment/ENV-admin-118.pdf>

заасан “Зөвшөөрөл, бүртгэл шаардах үйл ажиллагаа” гэдэгт актын Үйл ажиллагааны хавсралтад тусгасан үйл ажиллагаануудыг хамааруулах бөгөөд үүнд уурхай, нефть агуулсан элсний уурхай барьж байгуулах, ашиглах болон нөхөн сэргээх, нүүрс, нефть агуулсан элс баяжуулах үйлдвэр байгуулах, ашиглах болон нөхөн сэргээх ажлууд хамаарна. Харин “оператор” гэдэгт дараах этгээдүүдийг хамааруулжээ. Үүнд:

1. Тухайн газар дээр үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл болон бүртгэлийг эзэмшигч этгээд;
2. Тухайн газар дээр зөвшөөрөл эсхүл бүртгэлгүйгээр үйл ажиллагаа явуулж буй этгээд;
3. Тухайн газар дээр үйл ажиллагаа явуулах зорилгоор Албертагийн Эрчим хүчний зохицуулах газраас олгосон зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг эзэмшигч;
4. Цооног, уурхай, нүүрс баяжуулах үйлдвэр болон нефть агуулсан элсний баяжуулах үйлдвэрт хувь эзэмшиж буй оролцогч;
5. Тухайн газар дээр үйл ажиллагаа явуулах зорилгоор газар түрээслэх эрх бүхий этгээд;
6. Дээр дурдсан этгээдүүдийн эрх залгамжлагч, удирдлагууд.

Алберта мужийн уул уурхайн салбарын онцлог нь нэг цонхны бодлого баримтлан, уул уурхай, газрын тос, эрчим хүчний салбарыг удирддаг ба төрийн нэг байгууллагаар дамжуулан бүхий л тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох болон тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй харилцах явдал юм. Нэг цонхны бодлого хэрэгжүүлэх байгууллага нь Албертагийн Эрчим хүчний зохицуулах газар юм. Тус байгууллага нь 2012 онд батлагдсан Хариуцлагатай эрчим хүчийг хөгжүүлэх тухай акт (*Responsible Energy Development Act*)-ын хоёрдугаар зүйлд заасан Алберта мужийн эрчим хүчний эх үүсвэрийг үр дүнтэй, аюулгүйгээр, байгаль орчинд хор нөлөөгүй байдлаар хөгжүүлэх, нийтийн эзэмшлийн газрын эрхийг бусдад шилжүүлэх, менежментийг хэрэгжүүлэх, ус ашиглах эрх олгох, орчныг хамгаалах, хяналт шалгалт хийх зэрэг

бүрэн эрх хэрэгжүүлдэг. Мөн тус актын 2(2)-т заасны дагуу уул уурхай, газрын тосны хоолой, баяжуулах үйлдвэр, газрын тосны цооног ажиллуулахад шаардлагатай зөвшөөрөл олгох болон Байгаль орчныг хамгаалах, сайжруулах актад заасны дагуу өргөдөл, гомдол хүлээн авч, шийдвэрлэх эрхтэй. Тэрчлэн Усны актын дагуу өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх, орхигдсон болон хаагдсан уурхайнуудыг бүрэн хааж, нөхөн сэргээх асуудлыг хариуцдаг.

Албертагийн Эрчим хүчний зохицуулах газар уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч операторуудын үйл ажиллагаа байгаль орчны хууль тогтоомжид нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийдэг. Техникийн тусгай шинжээчид мэдээллийн үндсэн дээр тухай бүр хяналт шалгалт хийдэг. Ийнхүү хяналт шалгалтад хамрагдах операторуудыг тодорхойлохдоо зөрчил гаргаж байсан түүх (өмнөх шалгалтын үр дүн), үйл ажиллагаа явуулж буй газрын шинж байдал (усны эхтэй ойрхон байрладаг гэх мэт), тухайн бүс нутгийн байгаль орчны бохирдлын хэмжээ, давтамжийг харгалзана. Ямар нэг зөрчил үүссэн тохиолдолд эрсдэлийн зэрэг, үйл ажиллагааны цар хүрээг харгалзан шийдвэр гаргана.⁵⁰

Албертагийн Эрчим хүчний зохицуулах газар нь төлөвлөгөөт шалгалтыг үйл ажиллагааны эрсдэл, уурхай байрлах газрын шинж байдал, операторын үйл ажиллагааны түүх зэргийг харгалзан хийдэг бол олон нийтээс ирүүлсэн гомдол, мэдээлэлд үндэслэн төлөвлөгөөт бус мөн гэнэтийн шалгалт хийх боломжтой.⁵¹

Албертагийн Эрчим хүчний зохицуулах газрын хянан шалгагчид дээж авах, хэмжилт хийх, туршилт явуулах, шаардлагатай мэдээ, тайлан, баримт бичиг гаргуулж авах, компьютерын системд шалгалт хийх, аливаа этгээдийг байцаах, гэрэл зураг авах, видео болон аудио бичлэг хийх, машин, тоног төхөөрөмж, байгууламж зэргийг дайчлан ашиглах эрхтэй.

⁵⁰ Алберта мужийн Эрчим хүчний зохицуулах газар.
<https://www.aer.ca/regulating-development/compliance/inspections-and-audits.html>

⁵¹ Алберта мужийн Эрчим хүчний зохицуулах газар. .
<https://www.aer.ca/providing-information/news-and-resources/enerfaqs-and-fact-sheets/enerfaqs-inspections-and-enforcement-of-energy-developments-in-alberta.html#1>

Хяналт шалгалтын явцад зөрчил илрүүлсэн тохиолдолд тодорхой хугацаа зааж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах бөгөөд хэрэв хүн ам, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь их бол үйл ажиллагааг нь шууд зогсоох эрхтэй. Зөрчил гаргасан тухай мэдэгдэл хүргүүлэх (ямар хууль тогтоомж зөрчсөнийг тодорхойлж, цаашид авах арга хэмжээний зөвлөмж өгөх), сануулах, захирамж гаргах (үйл ажиллагааг нь зогсоох, байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхийг шаардах), захиргааны шийтгэл (зөрчил давтан гаргасан операторуудын үйл ажиллагааг хязгаарлах, бүхэлд нь зогсоох, зөвшөөрлийг нь цуцлах) болон торгууль ногдуулах, зөрчил шалгах хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах (шүүхийн журмаар) зэрэг арга хэмжээний аль нэгийг авдаг байна.

Торгуулийн шийтгэлийн хувьд хамгийн ихдээ нэг өдөрт 5,000 канад доллар байх бөгөөд зөрчил үргэлжилсэн өдрийн тоогоор үржүүлж ногдуулдаг байна. Тухайлбал, зөрчлийг арилгахгүй 10 өдөр болсон тохиолдолд 50,000 канад долларын торгууль ногдуулна гэсэн үг юм. Мөн торгуулийн хэмжээг тухайн зөрчлийн шинж чанар, хэмжээнээс хамааруулан ялгавартай ногдуулдаг.⁵²

⁵² Алберта мужийн Эрчим хүчний зохицуулах газар.
<https://www.aer.ca/regulating-development/compliance/compliance-and-enforcement-tools/administrative-penalty.html>

СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ

ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОГТОЛЦОО

Уул уурхайн салбар дахь байгаль орчны хяналт шалгалтын асуудлыг ТХШТХ, АМтХ, ТТАМтХ, БОХтХ, Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмаар зохицуулж байна. Гэхдээ эдгээр хууль тогтоомжид ойлгомжгүй, зохицуулалтгүй дутуу орхисон, хоорондоо давхардсан болоод зөрчилдсөн зүйл, заалт цөөнгүй байгаа нь хууль тогтоомж ойлгомжтой, тодорхой байх үндсэн зарчимд нийцэхгүй байна.

Хяналт шалгалтын тогтолцоог ТХШТХ-д тодорхойлохдоо мэргэжлийн хяналтын байгууллага, яам, агентлаг, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагуудын “хяналт тавих”, “хяналт шалгалт хийх” бүрэн эрхийн ялгаа заагийг ойлгомжтой хуульчлаагүйгээс мэргэжлийн хяналтаас бусад төрийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагууд “хяналт тавих” эрх хэмжээгээ хэтрүүлэн, хяналт шалгалт хийх болсон байна. Ийнхүү өөр олон байгууллагаас ирэх давхардсан шалгалт нь шалгуулагч аж ахуйн нэгжүүдэд дарамт, чирэгдэл учруулдаг нь ТХШТХ-д заасан хяналт шалгалтыг давхардуулахгүй байх үндсэн зарчимтай зөрчилдөж байна. Тухайлбал, уул уурхайн салбарт УУХҮЯ, АМГТГ, БОАЖЯ, нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын хяналт шалгалтад мөрдөх нэгдсэн журам байхгүйгээс ихэвчлэн мэргэжлийн хяналтын байгууллагад зөвлөн туслах хэлбэрээр хамтарсан ажлын хэсэг байгуулах замаар ажиллаж байна. Тэрчлэн орон нутагт аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газар, цагдаагийн байгууллага хамтарсан шалгалт хийдэг практик түгээмэл болжээ. Төрийн захиргааны төв байгууллагууд нь хяналт шалгалтад баримтлах нэгдсэн журам байхгүйгээс тухайлсан тохиолдол бүрд өөр өөрөөр хэрэгжүүлж байна.

Нөгөөтээгүүр дээрх төрийн захиргааны байгууллагын албан хаагчид улсын байцаагчийн эрхгүй, эдгээр байгууллагын хяналт шалгалт нь

албан бус шинж чанартайгаас шалгалтын үеэр үзлэг, туршилт хийх, дээж, шинжилгээ авах, машин техник битүүмжлэх, үйл ажиллагааг нь зогсоох, зөрчил арилгуулах, хариуцлага оногдуулах гэх мэт шаардлагатай арга хэмжээ авах боломжгүй байна.

Монгол Улс хүрээлэн байгаа орчныг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх зорилгоор 2020 онд экологийн цагдаагийн албыг шинээр байгуулжээ. Гэсэн ч экологийн цагдаагийн албаны харьяалан шалгах зөрчил хэт хязгаарлагдмал буюу Усны тухай хуулийн тодорхой зөрчлийг хянан шийдвэрлэхээр байгаагаас уул уурхайн салбарт гардаг байгаль орчны зөрчлүүдийг хойшлуулшгүй журмаар хянан шалгах боломжгүй. Иймээс экологийн цагдаагийн алба нь уул уурхайтай холбоотой иргэдээс ирсэн гомдол, мэдээллийг мэргэжлийн хяналтын байгууллагад уламжлахаас өөр арга хэмжээ авч чаддаггүй байна. Мөн мэргэжлийн хяналтын байгууллага нь хойшлуулшгүй ажиллагаа хийх боломжгүй бөгөөд иргэдийн гомдол, мэдээллийн үндсэн дээр төлөвлөгөөт бус шалгалт хийдэг боловч энэ тухайгаа зөрчил гаргагчид таваас доошгүй хоногийн өмнө заавал урьдчилан мэдэгдэх шаардлагатай болдог.

Хяналт шалгалтын тогтолцооны анхаарал татсан өөр нэг асуудал бол мэргэжлийн хяналтын байгууллагын босоо тогтолцоонд хамаарах сумын байгаль орчны байцаагчийг сумын Засаг даргын Тамгын газраас томилдог явдал юм. Ийнхүү сумын Засаг даргын Тамгын газраас байцаагчийг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилдог боловч улсын байцаагчийн эрхийг нь МХЕГ-аас олгодог байна. Сумын байгаль орчны байцаагч нь ийнхүү Засаг даргын Тамгын газарт харьяалагддагаас албан тушаалын зэрэг дэв, цалин хангамж нь мэргэжлийн хяналтын газарт харьяалагддаг байцаагчийнхаас доогуур байна.

Тэрчлэн байгаль хамгаалагчийг сумын Засаг дарга томилох ёстой боловч практикт тухайн аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар харьяалан томилдог ажээ. Байгаль хамгаалагч нь ийнхүү мэргэжлийн хяналтын байгууллагын босоо тогтолцоонд хамаардаггүйгээс тэднийг чадавхжуулах, шаардлагатай багаж хэрэгслээр хангах асуудал орхигдож байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн салбар дахь хяналт шалгалтын үр нөлөөг үнэлэхэд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны үүргийн хэрэгжилт, бодит байдалд бий болсон байгаль орчны сөрөг нөлөөллийг гол шалгуур болгон авлаа. Гэхдээ одоогоор зөвхөн уул уурхайн салбар гэлтгүй бусад бүх салбарт хяналт шалгалтын үр нөлөөг ямар шалгуураар, хэрхэн үнэлэх нь тодорхойгүй байгааг энд онцолж байна.

ТХШТХ 2003 онд батлагдсанаас хойш нэлээд хэдэн удаа өөрчлөгдөж байсан боловч тухайн салбар, аж ахуйн нэгжийн онцлогийг харгалзан хяналт шалгалтыг үр нөлөөтэй явуулахад хангалттай зохицуулалт болж чадахгүй хэвээр байна. Тухайлбал, мэргэжлийн хяналтын байгууллагаас практикт хэрэгжүүлж ирсэн урьдчилан сэргийлэх шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ зэрэг нь одоо болтол хуульчлагдаагүй байгаагаас гадна хяналтын явцад хойшлуулшгүйгээр хийдэг олон ажиллагаанаас ганцхан дээж, шинжилгээ авахад баримтлах журмыг тодорхойлжээ. Харин үзлэг хийх, ариутгал, хоргүйжүүлэлт хийх, машин, тоног төхөөрөмж ашиглахыг зогсоох ажиллагааны журам тодорхойгүй хэвээр байна.

МХЕГ-ын зүгээс хяналт шалгалттай холбоотой заавар, журмуудыг батлан гаргадаг боловч тэдгээр нь захиргааны хэм хэмжээний актад тавигдах шалгууруудыг хангаагүй, нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байх учир тухайн журмууд хүчин төгөлдөр бус болж байгаа юм. Улмаар хүчин төгөлдөр бус журмын дагуу хяналт шалгалт хийсэн гэж аж ахуйн нэгжүүд маргаан үүсгэх, хяналт шалгалтын үр дүнг бүхэлд нь хүчингүй болгох эрсдэл дагуулж байна. Аж ахуйн нэгжүүдийн зүгээс захиргааны хэм хэмжээний актын бүртгэлд бүртгэгдээгүй журмуудыг заавал биелэгдэх шинжтэй биш гэж үзэн маргах тохиолдол шүүх дээр цөөнгүй гардаг.

Хяналт шалгалтын төлөвлөгөөг эрсдэлийн ангилалд үндэслэн гаргадаг нь манай орны хувьд, ялангуяа уул уурхайн салбарт төдий л оновчтой бус байж болох юм. Уул уурхайн үйл ажиллагааны онцлогоос хамааран байгаль орчны эрсдэл хэдийд ч үүсэж болох ба зөвхөн эрсдэлтэй гэж үнэлэгдсэн аж ахуйн нэгжид л эрсдэл үүснэ гэсэн ойлголт байхгүй юм. Иймд гэнэтийн, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гомдол, мэдээллийн үндсэн дээр шуурхай хэрэгжүүлэх боломжийг өргөжүүлэх

шаардлагатай. Төлөвлөгөөт шалгалтын товыг өмнөх жилийн 12 дугаар сард гарган, нийтэд мэдээлдэг бол аваар осол гарч, эрсдэл, хохирол учирсан үед хийх төлөвлөгөөт бус шалгалтыг ч шалгуулагчид таваас доошгүй хоногийн өмнө мэдэгддэг. Энэ нь зөрчил, холбогдох нотлох баримтыг нуун дарагдуулах, зөрчил гарсан газрыг орхин зайлах боломж олгон, хяналт шалгалтын үр нөлөөг бууруулж байна.

Хяналт шалгалтыг зөвхөн хяналтын хуудасны дагуу гүйцэтгэх боловч түүний агуулгыг дахин сайжруулах хэрэгцээ үүсжээ. Тухайлбал, хяналтын хуудасны дагуу тухайн уурхайд холбогдох зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлт, тайлан, төлөвлөгөөг батлуулсан эсэхийг л харахаас бус, эдгээр баримт бичиг нь агуулгын хувьд хэр зэрэг үнэн бодитой, чанартай болохыг шалгах боломжгүй байна. Өөрөөр хэлбэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ үнэн зөв хийгдээгүй бол байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дагаад чанаргүй, бодитой бус байх болно.

Мөн хяналтын хуудсыг хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна. Тухайлбал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” 2019 онд шинэчлэгдсэн атал энэхүү судалгааны хугацаанд буюу 2020 оны 9 дүгээр сарын байдлаар хяналтын хуудсанд шинээр батлагдсан журмын дагуу нэмэлт өөрчлөлт оруулаагүй, хүчингүй болсон хуучин журмыг удирдлага болгосон хэвээр байна.

Дээж авах, сорьцыг шинжилгээнд өгөх, шинжилгээний хариу хүлээх зэрэг тодорхой хугацаа шаардсан процессын улмаас улсын байцаагчид хяналтын хуудсанд заасан зарим зүйлийг шалгахгүй орхих, шалгуулагчаас гаргаж өгсөн баримтад үндэслэн шийдвэр гаргах нөхцөл бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, хяналт шалгалт хийж буй улсын байцаагчийг хяналтын хуудсанд заасан бүх үзүүлэлтийг газар дээр нь шалгах боломжтой тоног төхөөрөмжөөр хангаагүй нь хяналт шалгалтын үр нөлөө буурах нэг шалтгаан болж байна.

Салбарын хууль тогтоомж нь ТХШТХ-д нийцээгүйгээс мэргэжлийн хяналтын байгууллага, албан тушаалтан хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж чадахгүй байна. Тухайлбал, мэргэжлийн хяналтын байгууллага нь зөрчил арилгах тухай шаардлагыг аж ахуйн нэгж

биелүүлээгүй тохиолдолд ТХШТХ-ийн дагуу ашигт малтмал олборлох, ашиглах, хайх үйл ажиллагааг бүрмөсөн зогсоох тухай санал, дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй. Гэсэн ч АМТХ-д мэргэжлийн хяналтын байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэн тусгай зөвшөөрөл цуцлах зохицуулалт байхгүй тул хүсэлт, дүгнэлт явуулсан ч үр дүнгүй байдаг байна.

Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн хэмжээ хэт бага байгаа нь уул уурхайн компаниудын хариуцлагыг сайжруулахад нөлөөлж чадахгүй байна.

СУДАЛГААНЫ ЗӨВЛӨМЖ

ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- ТХШтХ-д хяналт шалгалтын тогтолцоо, хэрэгжүүлэх байгууллага, тэдгээрийн эрх хэмжээг шинэчлэн тодорхойлж, хяналтын болон хяналт шалгалтын эрх хэмжээний хүрээ хязгаар, хэрэгжүүлэх арга хэлбэрийг тодорхой болгох;
- Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай гэх мэт салбарын хууль тогтоомжийг ТХШтХ-д нийцүүлэн өөрчлөх. Тухайлбал, Байгаль орчныг хамгаалах тухай хууль дахь хяналтын тогтолцоог ТХШтХ-д нийцүүлэх;
- Сумын байгаль орчны улсын байцаагчийг Засаг дарга томилж байгаа нь түүнийг мэргэжлийн хяналтын байгууллагын босоо тогтолцооноос тусгаарлан албан тушаалын зэрэг дэв, цалин хангамж, нийгмийн баталгаа зэрэг эрх зүйн байдлыг нь дордуулж байгааг өөрчлөх;
- Байгаль хамгаалагчийг хуульд зааснаас өөр практикаар аймгийн Байгаль, орчин, аялал жуулчлалын газар томилж байгаа явдлыг эргэн дүгнэж, нэг мөр хэрэгжих тодорхой зохицуулалт бий болгох;
- Байгаль хамгаалагчийн томилгооны журмыг хуульд нийцүүлэх, чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардагдах бүрэн эрх, баталгааг хуулиар бий болгох;
- Хууль тогтоомж дахь нэр томъёоны зөрүүтэй байдлыг арилган, нэг мөр хэрэгжүүлэх боломжтой болгох. Тухайлбал, зарим хуульд “улсын хяналт” гэж томъёолсныг “төрийн хяналт” болгон өөрчлөх, АМтХ-д “мэргэжлийн хяналтын алба” гэж заасныг “мэргэжлийн хяналтын байгууллага” болгох;

- ТХШтХ-ийн дагуу хэрэгжүүлж буй төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт шалгалт нь уул уурхайн салбарын онцлогт бүрэн нийцэхгүй байх тул урьдчилан сэргийлэх хяналт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд “гэнэтийн” шалгалт хийх боломжийг хуульчлах;
- Экологийн цагдаагийн албаны хянан шийдвэрлэх зөрчлийн хүрээг өргөтгөн, уул уурхайтай холбоотой байгаль орчны зөрчлийг шалган шийдвэрлэх, хойшлуулшгүй ажиллагаа явуулж зөрчлийг таслан зогсоох боломж бүрдүүлэх;
- Байгаль орчны зөрчилд хүлээлгэх хариуцлагыг чангатгах.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- Байгаль орчны хяналт шалгалтын объектын эрсдэлийн түвшнийг тогтоох үзүүлэлтүүдийг шинэчлэн, уул уурхайн салбарын онцлогт нийцсэн үнэлгээний шалгуур гаргах. Ингэхдээ Австрали, Канад улсуудын туршлагыг харгалзан тухайн компанийн үйл ажиллагааны түүх буюу өмнө гаргасан зөрчлөө арилгасан байдлыг харгалзан эрсдэлийг тодорхойлдог болох;
- Хяналтын хуудсыг уул уурхайн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн өөрчлөх, түүнийг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
- Уул уурхайн компаниудын удирдлага болон холбогдох ажилтнуудыг чадавхжуулах, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулах;
- Төрийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр хувийн хэвшлийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжихэд анхаарч, шаардлагатай мэдээллийн бааз суурийг бэхжүүлэн, хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зөвлөн туслах.

МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙГ
ЧАДАВХЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

- Ажлын бодит ачаалал, үр нөлөөг харгалзан байгаль орчны улсын байцаагчдын тоог нэмэгдүүлэн, тэднийг сургаж, чадавхжуулах үйл ажиллагааг системтэйгээр тогтмол зохион байгуулах;
- Байгаль орчны улсын байцаагчдын үйл ажиллагаа, ур чадвар, ажлын үр дүнг үнэлэх шалгуур, арга хэлбэрийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцох дотоод механизм бүрдүүлэх;
- Улсын байцаагч, байгаль хамгаалагчдын томилгооны шалгуур, үйл явцыг сайжруулж, ажил үүргээ ил тод гүйцэтгэхэд шаардлагатай багаж хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжөөр хангах, аюулгүй байдал, нийгмийн бусад баталгааг сайжруулах.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. НОМ, ТОВХИМОЛ

1. Б.Гүнбилэг, И.Идэш, *Эрдэс баялгийн эрх зүйн тойм*, УБ., 2012.
2. Ё.Бямбатогтох, *Төрийн хяналт шалгалт*, Хоёр дахь хэвлэл, УБ., 2005.
3. Э.Байгал, Д.Баяр болон бусад, “Гадаадын хөрөнгө оруулалт: Эрх зүйн асуудал” гарын авлага, УБ., 2010.
4. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, “Хариуцлагатай уул уурхай” гарын авлага, УБ., 2016.
5. *Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан*, УБ., 2020.
6. Department of Environment Regulation, *DER Annual Review and Compliance Program: 2016-17 priorities and targets*, AU., 2017.
7. Department of Environment Regulation, *Guidance Statement: Risk Assessments*, AU. (February 2017).
8. Department of Mines, Industry Regulation and Safety, *Guidance Note on Environmental Non-compliance and Incident Reporting*, AU., 2019.
9. Нээлттэй Нийгэм Форум, *Олборлох салбарын ашиг хүртэгч эцсийн эздийн ил тод байдлын судалгаа*, УБ., 2017.
10. Нээлттэй Нийгэм Форум, “*Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын хуулийн хэрэгцээ, шаардлага*” урьдчилсан тандан судалгаа, УБ., 2020.

Б. ХУУЛЬ ТОГТООМЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Төрийн хяналт шалгалтын тухай хууль, 2003.
3. Ашигт малтмалын тухай хууль, 2006.
4. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995.
5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012.
6. Зөрчлийн тухай хууль, 2017.
7. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017.
8. Усны тухай хууль, 2012.
9. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.

10. Төрийн албаны тухай хууль, 2017.
11. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014.
12. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хууль, 2017.
13. Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам.
14. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам.
15. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал.
16. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн систем, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”.
17. БОАЖ-ын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам.
18. БОАЖ-ын сайдын 2019 оны А/809 дугаар тушаалаар батлагдсан Байгаль орчны аудит хийх эрх олгох журам.
19. Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2019 оны А/67 тоот тушаал “Мэргэжлийн хяналт, шалгалтын ерөнхий шаардлага, стандарт батлах тухай”.

В. ЦАХИМ ЭХ СУРВАЛЖ

Монгол Улсын Хууль зүйн нэгдсэн сан. www.legalinfo.mn

Улсын Дээд Шүүх. www.supremecourt.mn

Алберта мужийн Эрчим хүчний зохицуулах газар. <https://www.aer.ca/regulating-development/compliance/compliance-and-enforcement-tools/administrative-penalty.html>

Department of Mines, Industry Regulation and Safety. <https://www.dmp.wa.gov.au/>

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. www.inspection.gov.mn

Азийн Сан. www.asiafoundation.org

Төрийн албаны зөвлөл. www.csc.gov.mn

Ашигт малтмал, газрын тосны газар. www.mrpam.gov.mn

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Засгийн газар, яам, агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалттай холбоотой зохицуулалт

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зүйл, заалтын агуулга
1	ТХШтХ-ийн 5.2	Төлөвлөгөөт болон төлөвлөгөөг бус хяналт шалгалтыг эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу хийх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: - он, сар, өдөр, удирдамжийн нэгдсэн дугаар; - шалгалтын зорилго, үндэслэл; - шалгалтын төрөл, арга, хэлбэр; - шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, объектын нэр; - шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч; - шалгалт эхлэх болон дуусах хугацаа; - өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл.
2	ТХШтХ-ийн 5.4	Хяналт шалгалтыг холбогдох асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргаж, түүнийгээ батлах замаар хийхийг хориглоно.
3	ТХШтХ-ийн 5.5	Хяналт шалгалтын бүрэлдэхүүнд төрийн болон төрийн бус, мэргэжлийн бусад байгууллага, шинжээч, шинжилгээний байгууллага, иргэнийг гатан оролцуулж болно.

Хавсралт 1-ийн үргэлжлэл

4	ТХШтХ-ийн 5.7	Хяналт шалгалтыг зөвхөн удирдамж, хяналтын хуудсанд заасан асуудлын хүрээнд хийж гүйцэтгэнэ.
5	ТХШтХ-ийн 5.15	Хяналт шалгалтын байгууллага, албан тушаалтан, хяналт шалгалтын ажилд оролцсон бусад этгээд хяналт шалгалтын явцад авсан мэдээллийг өөр зорилгоор ашиглахыг хориглоно.
6	ТХШтХ-ийн 5.16	Хяналт шалгалтын дүнгийн тухай танилцуулга, бусад баримт бичгийг зохих журмын дагуу үйлдэж, хяналт шалгалт хийсэн албан тушаалтан гарын үсэг зурна.
7	ТХШтХ-ийн 5.17	Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хяналт шалгалтын байгууллага хийсэн хяналт шалгалтынхаа дүнг эцэслэн гаргасны дараа ажлын 10 өдрийн дотор олон нийтэд нээлттэй болгоно.
8	ТХШтХ-ийн 5.1.2	Хяналт шалгалтын байгууллага төлөвлөгөөг хяналт шалгалт хийх тухайгаа шалгуулах этгээдэд таваас доошгүй хоногийн өмнө шуудангаар, утсаар эсхүл биечлэн мэдэгдэх бөгөөд мэдэгдэлд шалгалт хийх байгууллагын нэр, шалгалт эхлэх ба дуусах хугацааг заана.
9	ТХШтХ-ийн 5.1.3	Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн объект дээр хийх төлөвлөгөөг хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 15 өдрөөс илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүнг гаргах хугацаа болон санхүүгийн хяналт шалгалт хамаарахгүй.

Хавсралт 1-ийн үргэлжлэл

10	ТХШтХ-ийн 5 ^{1.4}	Төлөвлөгөөг хяналт шалгалт хийхэд тухайн хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтныг байлцуулах бөгөөд тухайн албан тушаалтан ирээгүй нь уг шалгалтыг хойшлуулах үндэслэл болохгүй.
11	ТХШтХ-ийн 5 ^{2.1}	Төлөвлөгөөг бус хяналт шалгалтыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр, түүнчлэн осол аваар, халдварт өвчин, хордлого зэрэг хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд буюу шууд бусаар хор хохирол учруулсан тохиолдолд болон хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр хийнэ.
12	ТХШтХ-ийн 5 ^{2.2}	Энэ хуулийн 5 ^{2.1} -д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгуулага өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээллийг зохих нотлох баримтын хамт хяналт шалгалтын байгууллагад ирүүлэх бөгөөд уг өргөдөл, хүсэлт, гомдол, мэдээлэл нь үндэслэлтэй гэж хяналт шалгалтын байгуулага үзсэн тохиолдолд хяналт шалгалтыг ажлын таван өдрийн дотор эхлүүлнэ.
13	ТХШтХ-ийн 5 ^{2.3}	Төлөвлөгөөг бус хяналт шалгалтыг гагцхүү түүнийг явуулах болсон үндэстэл, удирдамжид заасан асуудлын хүрээнд хийнэ.
14	ТХШтХ-ийн 5 ^{2.4}	Хуульд өөрөөр заагаагүй бол тухайн объект дээр хийх төлөвлөгөөг бус хяналт шалгалтын үргэлжлэх хугацаа ажлын 10 өдрөөс илүүгүй байх бөгөөд үүнд шалгалтын дүнг гаргах хугацаа хамаарахгүй.
15	ТХШтХ-ийн 5 ^{2.5}	Энэ хуулийн 5 ^{2.1} -д зааснаас бусад үндэслэлээр төлөвлөгөөг бус хяналт шалгалт явуулахыг хориглоно.

Хавсралт 1-ийн үргэлжлэл

16	ТХШтХ-ийн 5 ³ .1	Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар хяналт шалгалтын байгууллагаас өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор явуулна.
17	ТХШтХ-ийн 5 ³ .2	Гүйцэтгэлийн шалгалтыг өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил, түүний шалтгаан, нөхцөлийг арилгуулахаар өгсөн албан шаардлагын хүрээнд хийнэ.
18	ТХШтХ-ийн 5 ³ .3	Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ.
19	ТХШтХ-ийн 13.2	Байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн албан тушаалтан нь хяналт шалгалтын ажилд дэмжлэг тусалцаа үзүүлж, хяналт шалгалт хийх эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, хууль зөрчсөн үйл ажиллагааг зогсоох, холбогдох арга хэмжээ авах талаар тавьсан шаардлагыг биелүүлж, дүнг тогтоосон хугацаанд нь албан ёсоор мэдэгдэх үүрэгтэй.
20	ТХШтХ-ийн 14.1	Шалуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид гаргана.
21	ТХШтХ-ийн 14.2.	Гомдлыг хүлээж авсан хяналт шалгалтын байгууллагын эрх баригч түүнийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна. Хэрэв гомдол гаргасан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын байгууллагын шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргаж болно.

Хавсралт 2. Ашигт малтмалын тухай хуулийн мэргэжлийн хяналттай холбоотой заалтууд

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зүйл, заалтын агуулга
1	АМтХ-ийн 20.7	Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон даруйд энэ тухай байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
2	АМтХ-ийн 22.3	Төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгамагц энэ тухай мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
3	АМтХ-ийн 26.7	Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл болон үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын долоон өдөрт багтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.
4	АМтХ-ийн 35.2.3	Төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын албаар хянуулсан хайгуулын ажлын төлөвлөгөөг хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа газар дээр байлгана.

Хавсралт 2-ын үргэлжлэл

5	<p>АмтХ-ийн 36.1</p> <p>Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь энэ хуулийн 26.5-д заасны дагуу тусгай зөвшөөрлийн бүртгэлд бүртгүүлснээс хойш гурван сарын дотор мэргэжлийн хяналтын албаны тавьсан техникийн шаардлагын дагуу уурхайн талбайн хилийг тогтоолгож, байнгын шав тэмдэг тавих бөгөөд уурхайн талбайн хилийн хэмжилтийг төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан этгээдээр хийлгэн, хил тогтоосон тухай актыг тус албанд ирүүлнэ.</p>
6	<p>АмтХ-ийн 39.1.7</p> <p>Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд тус тус хүргүүлнэ.</p>
7	<p>АмтХ-ийн 39.7</p> <p>Тухайн жилийн нөхөн сэргээлтийн ажлыг бүрэн хийгээгүй тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга болон мэргэжлийн хяналтын алба хамтран дараагийн жилийн олборлолтын ажлыг эхлүүлэхгүй байх эрхтэй.</p>
8	<p>АмтХ-ийн 45.1.3</p> <p>Тухайн нутгийн захиргааны байгууллага эсхүл мэргэжлийн хяналтын албанаас талбайд үлдээхийг зөвшөөрснөөс бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг талбайгаас гаргах.</p>
9	<p>АмтХ-ийн 45.2</p> <p>Уул уурхайн үйлдвэрлэлийн улмаас үүсэж бий болсон, аюул учруулж болзошгүй газруудыг зохих масштабын газрын зураг дээр нарийвчлан гэмдэглэж, шаардлагагай тэмдэг, дохио, сануулгыг уурхайн эдэлбэрийн орчинд байрлуулах бөгөөд газрын зургийг мэргэжлийн хяналтын алба болон тухайн сум, баг, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.</p>

10	АМтХ-ийн 47.9.	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын ажлын явцад туршилтын журмаар олборлосон ашигт малтмалын төрөл, тоо, хэмжээг мэргэжлийн хяналтын албанд бүртгүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр худалдан борлуулж болно.
11	АМтХ-ийн 48.1	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах мэдээ, тайлан, төлөвлөгөөг дор дурдсан хугацаанд үнэн зөв гаргаж төрийн захиргааны байгууллага болон мэргэжлийн хяналтын албанд хүргүүлнэ.
12	АМтХ-ийн 49.11	Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэсэн талаар мэргэжлийн хяналтын алба, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ.

Хавсралт 3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хүрээнд уул уурхайн салбарт хийгдэх хяналт шалгалтад хамаарах заалтууд

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зүйл, заалтын агуулга
1	БОХтХ-ийн 3.2.7	“Байгаль орчныг хамгаалах” гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, гэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна.
2	БОХтХ-ийн 3.2.11	“Байгаль орчинд учруулсан хохирол” гэж байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтэсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг.
3	БОХтХ-ийн 3.2.14	”Байгаль орчны аудит” гэж байгаль орчны хууль тогтоомж, төрийн бодлого, үндэсний хөтөлбөрийн биелэлт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын хэрэгжилтийг хянаж, дүгнэлт гаргах, мэргэжлийн зөвлөгөө өгөх хараат бус үйл ажиллагааг.
4	БОХтХ-ийн 5.1	Төр нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор байгаль орчинд хортой нөлөөлөхөөс болон байгаль орчны тэнцэл алдагдахаас сэргийлэн хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5	БОХТХ-ийн 5.2	Төр нь байгаль орчныг хамгаалах чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах зарчим баримтална: 1) хүний амьдрах, хөдөлмөрлөх, амрах байгаль орчны тааламжтай нөхцөл бүрдүүлэх; 2) экологийн баримжаатай эдийн засгийг хөгжүүлж байгаль орчны тэнцлийг хангах; 3) байгалийн баялгийг шинжлэх ухааны үндэслэлтэй, зохистой ашиглах нөхцөлийг хангах; 4) байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг ашиглах шийдвэр, үйл ажиллагаа ил тод байх; 5) байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах.
6	БОХТХ-ийн 6.2	Хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгуулага, гадаадын иргэн, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамж төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно.
7	БОХТХ-ийн 7.1	Байгаль орчны унаган төрхийг хадгалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах зорилгоор байгалийн баялгийн нөөцийн үнэлгээ болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг тус тус хийнэ.
8	БОХТХ-ийн 7.3	Байгаль орчны үнэлгээг энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу эрх олгосон аж ахуйн нэгж, байгууллага хийж, тухайн төрлийн байгалийн баялгийг хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
9	БОХТХ-ийн 13.3	Улсын Их Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 3) байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих.

Хавсралт 3-ын үргэлжлэл

- | | | |
|----|------------------|---|
| 10 | БОХТХ-ийн 15.1.1 | Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1) байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчны тэнцлийг хангах, байгаль орчинд учирч болох хохирлоос урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг арилгуулах төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах. |
| 11 | БОХТХ-ийн 15.1.7 | Байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслацаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх. |
| 12 | БОХТХ-ийн 16.2.4 | Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх. |
| 13 | БОХТХ-ийн 16.2.5 | Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэртээ ажиллах байгаль орчны улсын ахлах болон улсын байцаагчийг энэ хуульд заасны дагуу ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар хангах. |

Хавсралт 3-ын үргэлжлэл

-
- 14 БОХтХ-ийн 16.2.6 Аймаг, нийслэлийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагагай зөвшилцөж томилох, чөлөөлөх.
-
- 15 БОХтХ-ийн 16.3 Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны даргыг байгаль орчны мэргэжилтэй иргэдээс Төрийн албаны тухай хуулийн 25, 26, 27 дугаар зүйлд заасны дагуу сонгон шалгаруулж томилно.
-
- 16 БОХтХ-ийн 17.2.4 Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагагай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.
-
- 17 БОХтХ-ийн 17.2.5 Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: байгаль хамгаалагчийн ажлыг удирдан чиглүүлэх, албан үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах ялгаж тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах зэвсэг, техник хэрэгсэл, уналгаар орон нутгийн төсөвтөө тусган хангах, шаардлагагай бусад тусалцаа үзүүлэх.
-

Хавсралт 3-ын үргэлжлэл

18	БОХтХ-ийн 17.2.7 Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: энэ хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтад заасан шийдвэрийг үндэслэн иргэдийн нөхөрлөлд хариуцуулах байгалийн тодорхой төрлийн баялгаас нь зохих болзол, хугацаатайгаар хууль, журмын дагуу хамгаалуулах, ашиглуулах, эзэмшүүлэх гэрээ байгуулж, биелэлтэд нь хяналт тавих.
19	БОХтХ-ийн 17.2.8 Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах.
20	БОХтХ-ийн 17.2.9 Сум, дүүргийн Засаг дарга байгаль орчныг хамгаалах, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан үүргээ нутгийн иргэдийн байгалийн нөөцийг зохистой ашиглах ухамсрыг төлөвшүүлэх, байгалийн нөөцийн хууль бус ашиглалттай тэмцэх, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, шүүхэд нэхэмжлэл гаргах зэрэг хэлбэрээр хэрэгжүүлэх.
21	БОХтХ-ийн 26.1-р зүйл Байгаль орчны хяналт

Хавсралт 3-ын үргэлжлэл

22	БОХтХ-ийн 26.2	Хил, гааль, мал эмнэлэг, эрүүл ахуй, халдвар судлал, уул уурхайн зэрэг хяналтын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож, хяналтын үүрэг гүйцэтгүүлж болно.
23	БОХтХ-ийн 26.3	Мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлэх төв байгууллагад улсын ерөнхий байцаагч, салбарын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, аймаг нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч, сум дүүрэгт улсын ахлах байцаагч, улсын байцаагч (цаашид “улсын байцаагч” гэх) болон байгаль хамгаалагч тус тус ажиллана.
24	БОХтХ-ийн 26.4.1	4.Улсын байцаагчийг дараах байдлаар томилж, чөлөөлнө: 1) улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10.4-т заасны дагуу олгоно.
25	БОХтХ-ийн 26.4.4	4) байгаль хамгаалагчийг энэ хуулийн 26 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт заасан нормативын дагуу сум, дүүргийн улсын байцаагчийн саналыг харгалзан сум, дүүргийн Засаг дарга.
26	БОХтХ-ийн 26.5	Байгаль орчны хяналтын улсын байцаагчаар байгаль орчны чиглэлийн мэргэжилтэй эсхүл энэ чиглэлээр мэргэшиж дадлагажсан дээд боловсролын зэрэгтэй иргэнийг томилно.
27	БОХтХ-ийн 26.6	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны чиглэлээр сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сургуулийн мэргэжлийн сургалтад хамрагдаж төгссөн иргэнийг байгаль хамгаалагчаар ажиллуулна.

28	БОХтХ-ийн 27-р зүйл Улсын байцаагчийн эрх үүрэг	<p>1. Улсын байцаагч дараах эрхтэй байна:</p> <p>1) иргэн, аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;</p> <p>2) хяналтад шаардагдах мэдээ, баримтыг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаар гаргуулах;</p> <p>3) хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь түр зогсоох;</p> <p>4) хяналт, шалгалт хийхээр аж ахуйн нэгж, байгууллагад нэвтрэн орох, сорьц, дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;</p> <p>5) байгалийн гамшиг, гэнэтийн аюулын үед шаардлагагай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;</p> <p>6) байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;</p> <p>7) Зөрчлийн тухай хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах;</p> <p>8) байгаль хамгаалагчийн ажлыг шалгах, заавар өгөх;</p> <p>10) хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лиценз, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах, үйл ажиллагааг түр болон бүрмөсөн зогсоох саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;</p>
----	--	---

11) байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх.

2. Улсын байцаагч дараах үүрэгтэй байна:

1) байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхдээ хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмыг чанд сахин биелүүлэх;

4) илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

б) байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах, зохион байгуулах, хамтарч ажиллах.

29 БОХХ-ийн 28-р

зүйл

Байгаль

хамгаалагчийн

эрх үүрэг

1. Байгаль хамгаалагч дараах эрхтэй байна:

1) нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 4, 5-д заасан улсын байцаагчийн эрхийг хэрэгжүүлэх;

2) нутаг дэвсгэртээ энэ хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, 7-д заасан улсын байцаагчийн эрхийг хуульд тусгайлан заасан тохиолдолд хэрэгжүүлэх.

2. Байгаль хамгаалагч энэ хуулийн 27 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас гадна дараах үүрэгтэй байна:

1) хариуцсан нутаг дэвсгэртээ байгаль орчинд учирч болзошгүй аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

2) хууль тогтоомжид заасан тохиолдолд байгалийн баялгийн нөөц ашиглах эрхийн бичиг олгох;

Хавсралт 3-ын үргэлжлэл

3) иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хяналт тавих;

4) хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийн өөрчлөлтийн ажиглалт хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

5) байгалийн гамшиг, гэнэтийн аюул гарсан даруйд зохих шатны Засаг даргад мэдээлж, хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

6) хариуцсан нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

7) хариуцсан нутаг дэвсгэртээ ажиллах нөхөрлөлийн менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

8) уул, ой модонд бүтсэн оргодол яллагдагч, ялтныг эрэн сурвалжилж байгаа цагдаагийн албанд газар орны онцлог, байгалийн тогтоц, байршлын талаар мэдээлэл өгөх, газарчлах, хамтран ажиллах;

9) хариуцсан нутаг дэвсгэртээ орших гол, мөрөн, нуурт усан замын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавих.

30 БОХТХ-ийн 28.3 Энэ хуулийн 26 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан шаардлага хангасан **байгаль хамгаалагчид байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх олгох бөгөөд эрх олгох журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хамтарч батална.**

31 БОХТХ-ийн 29.1 Улсын байцаагч, байгаль хамгаалагч хээрийн нөхцөлд хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үедээ галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгсэл биедээ авч явах эрхтэй.

Хавсралт 3-ын үргэлжлэл

32	БОХтХ-ийн 29.3 Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн этгээд улсын байцаагч, байгаль хамгаалагчийн хууль ёсны шаардлагыг хүч хэрэглэн эсэргүүцвэл резинэн болон цахилгаан бороохой, нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, резинэн буюу хуванцар сумтай буу зэрэг нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно.
33	БОХтХ-ийн 29(1) Улсын байцаагч, байгаль хамгаалагч нь нийгмийн болон эрхээ хэрэгжүүлэх дараах баталгаагаар хангагдана: 1) төрийн албанд 25 ба түүнээс дээш жил, түүнээс сүүлийн 10 жилийг нь байгаль хамгаалах албанд ажилласан байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарыг тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох; 2) ажил үүргээ гүйцэтгэх зориулалтаар унаа, дүрэмт хувцас, галт зэвсэг, бие хамгаалах тусгай хэрэгслээр хангагдах. 2. Улсын байцаагч, байгаль хамгаалагч албан үүргээ гүйцэтгэх явцдаа бусдын нөлөөгөөр хөдөлмөрийн чадвараа түр алдсан, хөгжлийн бэрхшээлтэй болсон, амь насаа алдсан тохиолдолд түүнд болон түүний ар гэрт дараах буцалтгүй тусламж, цалингийн зөрүүт олгоно: 1) хөдөлмөрийн чадвараа түр алдсан тохиолдолд эмнэлгийн чөлөөтэй байсан хугацааны тэтгэмж, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү; 2) хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр, албан тушаалын үндсэн цалингийн зөрүү; 3) амь насаа алдсан тохиолдолд ар гэрт нь хохирогчийн 3 жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж; 4) энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндсэн цалингийн зөрүү, буцалтгүй тусламжийг төсвөөс олгож, түүнтэй тэнцэх хөрөнгийг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ; 5) хуульд заасан бусад баталгаа.

Хавсралт 3-ын үргэлжлэл

34	БОХтХ-ийн 31.1	Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна: байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газар, нутгийн өөрөө удирдах байгууллага болон Засаг даргын шийдвэр, улсын байцаагч, байгаль хамгаалагчийн шаардлагыг биелүүлэх.
35	БОХтХ-ийн 31.2	Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна: эрх бүхий байгууллагаас багалсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх.
36	БОХтХ-ийн 31.8	Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна: хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хариуцлага хүлээлгэхийг Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагчаас шаардах.
37	БОХтХ-ийн 31.9	Аж ахуйн нэгж, байгууллага байгаль орчныг хамгаалах талаар дараах үүрэгтэй байна: өөрийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учруулсан хохирлыг арилгах, холбогдох байгууллагад мэдэгдэх, байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан нөхөн төлбөрийг ажлын 14 хоногт багтаан төлөх.
38	БОХтХ-ийн 54.4	Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

39	БОХТХ-ийн 54.5	Хууль бусаар бэлтгэж хураалгасан байгалийн баялгийн борлуулалтын орлогын 15 хувийг тухайн зөрчлийг илрүүлсэн улсын байцаагчид мэргэжлийн хяналтын байгууллага, байгаль хамгаалагчид тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.
40	БОНБУТХ-ийн 8.8	Төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллага нөлөөллийн үнэлгээ хийсэн эсэхэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.
41	БОНБУТХ-ийн 9.12	Байгаль орчны менежментийн болон уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавина.
42	БОНБУТХ-ийн 9.14	Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан болон энэ хуулийн 9.12, 9.13-т заасан хяналтын дүнг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн баталгааны мөнгийг буцаан олгох эсэх асуудлыг энэ хуулийн 9.15-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Хавсралт 3-ын үргэлжлэл

43	Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-05 дугаар тушаалын хавсралт	3.3. Төсөл хэрэгжүүлэгчээс тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймаг, нийслэлийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажиллуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулах ба уг ажлын хэсэгт аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хөгжлийн бодлогын хэлтэс, байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын газар, сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөл, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, газрын даамал орно.
	“Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан багтах, тайлагнах” журам	5.5. Ашигт малтмалын орд ашиглаж буй төсөл хэрэгжүүлэгч уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн 20... оны жилийн мэдээ маягт БОХ-3-ын дагуу холбогдох мэдээллийг гаргаж, тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор хүргүүлэх ба уг маягтыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд заавал хавсаргана.

Хавсралт 4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль: Уул уурхайн салбарт
гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх харьяалал

№	Хуулийн зүйл, заалт	Хуулийн зүйл, заалтын агуулга	Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан
1	Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйл	Химийн хорт, аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
		Хуульд заасны дагуу батлагдсан химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	

Хавсралт 4-ийн үргэлжлэл

Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2 Зөрчлийн тухай хуулийн 5.15 дугаар зүйл	Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журмыг ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах, уул уурхай, барилгын ажил, тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
--	--	--

Хавсралт 4-ийн үргэлжлэл

3	<p>Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйл</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.</p>
---	--	---

Хавсралт 4-ийн үргэлжлэл

4	Зөрчлийн тухай хуулийн 7.2 дугаар зүйл	Хуульд заасан хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, цөлжилттэй тэмцэх арга хэмжээний тухай журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
5	Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйл	Газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан эсхүл гэмтээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.

Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсэж болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хавсралт 4-ийн үргэлжлэл

6	Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйл	Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй, хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
		Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
		Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	

Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэг эсхүл өнгөг чулууг олборлосон, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, хадгалсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хавсралт 4-ийн үргэлжлэл

7	Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйл	Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон эсхүл борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
		Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	
		Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	

Хавсралт 4-ийн үргэлжлэл

Тайлбар: Энэ зүйлд заасан зөрчлийг үйлдсэн бол эрх бүхий улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг хоёр сар хүртэл хугацаагаар зогсоох ба энэ хугацаанд зөрчлийг засаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу цуцлах тухай асуудлыг тухайн тусгай зөвшөөрлийн талбай оршиж байгаа аймаг, нийслэлийн эрх бүхий албан тушаалтанд гаргана.

8	Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйл	Хуульд заасны дагуу усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, усны эх үүсвэрийн онцгой эсхүл энгийн хамгаалалтын бүс эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
---	---	---	--

Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан эсхүл бусдад шилжүүлсэн эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдирлыг өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуульд заасан усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх, усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт- шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хутацаанд нь явуулах, тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.27-р хэсгийг удирдлага болгон **улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч** мөн холбогдох зөрчлийг шалгах эрх хэмжээтэй.

Экологийн

цагдаагийн алба нь энэхүү заалтын дагуу зөрчлийн хэрэг үүсгэн шалгах, хариуцлага тооцох эрхтэй.

Хавсралт 4-ийн үргэлжлэл

Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9 Зөрчлийн тухай хуулийн 7.16 дугаар зүйл	Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан эсхүл худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
--	--	--

Хавсралт 4-ийн үргэлжлэл

	<p>Зөвшөөрөлгүйгээр эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.27-р хэсгийг удирдлага болгон улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч мөн холбогдох зөрчлийг шалгах эрх хэмжээтэй.</p>
<p>10 Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйл</p>	<p>Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>	<p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.</p>

Хавсралт 4-ийн үргэлжлэл

		<p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.27-р хэсгийг удирдлага болгон улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч мөн холбогдох зөрчлийг шалгах эрх хэмжээтэй.</p>
11	<p>Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйл</p>	<p>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль зөрчиж, сахин хангуулах үүргээ биелүүлээгүй, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм, журам хангаж ажиллаагүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p> <p>Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг нуун дарагдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.</p>

Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж барих, машин механизм, тоног төхөөрөмжийг суурилуулах, тэдгээрийг шинэчлэх, өргөтгөх, ашиглалтад өгөх, зуух, даралтаг сав, шугам хоолой, өргөх, зөөх механизмд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллаагүй бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан ажилтны хөдөлмөрийн чадвар алдалтын хувийг буруу тогтоосон бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Ажилтныг эрүүл мэндийн урьдчилсан ба хугацаат үзлэгт оруулаагүй бол хүнийг далан таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг долоон зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хавсралт 4-ийн үргэлжлэл

12 Зөрчлийн тухай хуулийн 11.2 дугаар зүйл	Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд хяналт шалгалтаас зайлсхийсэн, дотоод хяналт шалгалтын журам тогтоож мөрдүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10-р заалтыг удирдлага болгон мэргэжлийн хяналтын улсын байцаагч холбогдох зөрчлийг хянан шалгах чиг үүрэгтэй.
	Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд төрийн хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр тагталзсан, засварласан, гэмтээсэн, зайлсхийсэн, устгасан, хуурамч баримт бичиг гаргаж өгсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	

ISBN 978-9919-9812-8-0



9 789919 981280